

MONGOLIAN ECONOMY

2016 оны 03 сар №06 (108)

mongolianeconomy.mn

АСЕМ биднийг хүлээхгүй

Тэнгэр харсан тариалан

Хэрвээ Орос задарвал

1.5 тэрбум хүн


дэлхий даяар устай холбоотой салбаруудад ажилладаг. Бүх хүний ажил, амьдрал ус ба түүнийг аюулгүй хүргэх үүргийг хүлээдэг хүмүүсээс шалтгаалдаг



UN WATER

WORLD WATER DAY

22 MARCH 2016 - WATER AND JOBS





МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН



СУРГАМЖ, СОРИЛТ, ШИЙДЭЛ

2016 ОНЫ 3 ДУГААР САРЫН 30-31,
ТӨРИЙН ОРДОН

ЦАХИМ БҮРТГЭЛ

WWW.MEFORUM.MN/REGISTER

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

ВЭБ WWW.MEFORUM.MN
УТАС 11321051



МОНГОЛЫН БИЗНЕСИЙН ЗӨВЛӨЛИЙН АНХДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТ

Монгол улсын бизнесийн тогтвортой өсөлт ба хөгжлийг дэмжинэ

Оролцохын ач холбогдол?

Монголд үйл ажиллагаа явуулж буй бизнесийн байгууллага, мэргэжлийн хүмүүст ирээдүйд өсөж, хөгжихөд нь хэрэг болохуйц өргөн хүрээний, чухал бөгөөд шинэлэг мэдээ мэдээллийг олж авах

Дараагийн Засгийн газрын зүгээс анхаарвал зохих өнөөгийн бизнесийн салбарт тулгамдаж буй гол асуудлуудын талаар өөрийн үзэл бодлоо илэрхийлэх; Засгийн газар, улс төрийн намууд болон холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлэх Чуулга уулзалтын зөвлөмж бичигт өөрийн хувь нэмрийг оруулах

Хамрах хүрээ?

Бизнесийн төрөл бүрийн салбарын төлөөлөл болсон 200 хүн
Илтгэгч болон салбар хуралдааны зочдоор оролцох өндөр түвшний бизнесийн удирдагч, шийдвэр гаргагч 25 хүн

Платинум спонсор:



Алтан спонсор:



Мөнгөн спонсор:



Хэвлэл мэдээллийн спонсор:



Дэмжигч байгууллага:



Арга хэмжээний спонсор:



МБЗ чуулга уулзалтын дараах Хаврын Гала Үдэшлэгийн спонсор:



2016 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр Blue Sky зочид буудал

ДЭЛХИЙН ХӨТӨЧ

Бүтэн жилийн турш таны ширээн дээр



“Mongolian Economy” сэтгүүл “The Economist” сэтгүүлийн жилийн
“The World in 2016” дугаарыг тусгай зөвшөөрлийн хүрээнд монгол хэлээр гаргаад байна.

Дэлхий 2016: Энэ оныг гурван үгээр дүгнэж болох.

ЗОВЛОН ЗУДГУУР, ЭМЭГТЭЙЧҮҮД болон ЯЛАЛТ.

Энэ удаагийн дугаарт Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Моди зэрэг нөлөө бүхий улстөрчдөөс гадна тусгай бүлэгт Канадийн зохиолч, Америкийн чиг хандлага ажиглагч, Израилийн шинэлэг загвар зохион бүтээгч болон Австралийн алдартай зурхайч гэх мэтийн хүмүүс хувь нэмрээ оруулжээ. Тус сэтгүүлд дэвшүүлэн тавьсан таамаг төлөвийн 90 хувь нь биелдгээрээ давуу талтай гэдгийг сэтгүүлийн эрхлэгч Даниел Франклин онцлон тэмдэглэсэн. Тийм учраас сэтгүүлийн байнгын уншигчид жил бүр эргэн ирдэг.

Бид Монголын уншигчдыг ч энэ эгнээнд элсүүлж чадсандаа баяртай байна. Та бүхэн таалан уншина уу.

Үнэ: 40.000₮

Утас: 7011 5477, 7011 5476, 88006228, 94092904



ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

О.Түвшин

СЭТГҮҮЛЧИД:

Б.Үүрийнтуяа

Б.Энхцэцэг

Г.Орхон

Ц.Элбэгсайхан

ОРЧУУЛАГЧ:

Б.Энхмөнх

ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Барянжав

Хаяг: Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг,
I хороо, Экспресс тауэр. 1101 тоот

Вэб: www.mongolianeconomy.mn

И-мэйл: info@mongolianeconomy.mn

Утас: 976-7011 5476

Борлуулах цэгүүд:

“Интер ном”

“Цэцэг төв”

“Минж плаза”

“Алтантүлхүүр” номын дэлгүүр

“Номин” супермаркетин бүх

салбар

“Макс” супермаркетин бүх салбар

“Фреско” супермаркет

BTSI супермаркет

“Аз орчлон” номын дэлгүүр

“Билэг” их дэлгүүрийн номын тасаг

“Гранд Плаза” дахь супермаркет

“Мир” номын дэлгүүрийн:

“Grand plaza”

“Metro mall”

“Sky” супермаркет

“Улаанбаатар” их дэлгүүр

“Мах mall” дахь салбарууд



[facebook.com/
Mongolian.Economy](https://www.facebook.com/Mongolian.Economy)



[twitter.com/
EconomyMongolia](https://twitter.com/EconomyMongolia)



[youtube.com/user/
MongolianEconomy](https://www.youtube.com/user/MongolianEconomy)

Дэлхийн усны өдөрт

8 Чимээгүй салбар

Манайд ус үнэггүй шахам байгаа учраас бид үнэ цэнийг нь мэдрэх болоогүй байна. Улаанбаатар хотод л гэхэд л гэр хорооллын айл өрх нэг литр усыг нэг төгрөгөөр авдаг бол орон сууцны оршин суугчид 30-50 мөнгөөр авч байна.

10 С.Үнэн: Туул усан цогцолбор байгуулснаар усан хангамж 50-100 жилээр баталгаажина

Усны үнийг барих нь УСУГ-ыг хөгжил дэвшлийг боогдуулж байна, өрөнд оруулж байна.

15 Мөрөөдөл ойртох цагаар

Дөрөвхөн жилийн дараа хот даяараа ангаж цангахын зовлонг мэдэрч эхэлнэ. Учир нь нийслэлчүүдийг өнөөдөр ганцхан гүний усаар тэтгэж буй.

16 АСЕМ биднийг хүлээхгүй

Төв цэвэрлэх байгууламжийн асуудлыг ирэх долдугаар сараас өмнө амжиж шийдвэрлэхийг хотын удирдлагуудад Засгийн газраас үүрэгдсэн. Үнэн хэрэгтээ жинхэнэ даалгавар өгөгч нь АСЕМ юм.

20 “Усчдын” эрэлд

Өдгөө дэлхий даяар 1.5 тэрбум хүн устай холбоотой салбаруудад ажилладаг.

22 Яагаад Дэлхийн усны өдөр гэж?

Жил бүр усны өдрийг тодорхой сэдвээр “малгайлдаг” бөгөөд энэ нь тухайн жилийн ажил үүргийн чиг болдог.

25 Цэнхрээс ногоон

Дэлхийн эрсдэлийн тайлан-2016”-д хүн төрөлхтний туулж буй

хамгийн том гурван гачлангийн нэг нь усны хямрал гэжээ.

27 Тэнгэр харсан тариалан

Монгол Улсын хэмжээнд газар тариалангийн нийт эргэлтийн талбай нэг сая га орчим байгаагийн 800 мянга орчим га талбайг ашиглаж байгаа бол үүний 400 мянган га орчмыг усалгаатай болгох боломж байгаа аж.

Хэрвээ ингэвэл яах вэ

30 Хэрвээ Орос задарвал

Орос анх удаа хүчирхийлэл, газар нутгаа тэлэх оролдлого хийх замаар орчин үеийн чиг хандлагын эсрэг тэмцэх гэж үзээд эцэстээ өөрийн улс орны нэгдмэл байдлыг алдаж байгаа нь биш юм.

31 Итгэлцлийн гэрээ

Украин дахь Оросын түрэмгийлэл НАТО-д шинэ заналхийлэл, шинэ зорилго бий болгож өгсөн

Эдийн засаг

33 Зээлийн гэрээ: Хоёр үнэний хооронд

Иргэд хоорондоо хүүтэй мөнгө зээлүүлэхийг хуулиар хориглосон тухай мэдээлэл өнгөрсөн сард гарч олон хүнийг гайхашруулав.

34 Мальдив “мандсан” ITB Berlin 2016-гийн өдрүүд

Жил бүр нэг орон онцлох улсаар оролцдог ба түрүү жил Монгол улс байсан бол энэ удаа Мальдив өөрсдийгөө давуу эрхтэйгээр сурталчилж, тугаа мандууллаа


36 Улс төрийн соёл өдрүүд




С.Үнэн: Туул усан цогцолбор байгуулснаар усан хангамж 50-100 жилээр баталгаажина
Гадаргын усан хангамж руу шилжсэнээрээ Улаанбаатарын усан хангамж 50-100 жилээр найдвартай болно, хуудас 10



АСЕМ биднийг хүлээхгүй
Засгийн газар төв цэвэрлэх байгууламжийн үнэрийг дарахад зорилж 8.1 тэрбум төгрөгийг нэгдүгээр сарын 6-нд Нийслэлийн дансанд шилжүүлжээ, хуудас 16



Ус бол ажил
Яагаад Дэлхийн усны өдөр гэж?
хуудас 22



Хэрвээ Орос задарвал
200 гаруй үндэстнийг багтаасан, газар нутаг нь 11 цагийн бүсийг хамардаг Орос өөрөө дотроосоо задран унаж байвал яах вэ, хуудас 30

Нигери

Ерөнхийлөгч Мухаммаду Бухаригийн авлигын эсрэг кампанит ажлын хүрээнд Нигери улсын Сангийн яам 24 мянган бодит бус төрийн албан хаагчдад цалин олгож буйг илрүүлж тэднийг бүртгэлээс хасчээ. Нигери улс нь газрын тосны хамгийн том үйлдвэрлэгчдийн нэг. Сүүлийн жилүүдэд газрын тосны үнэ унах болсон нь эдийн засаг нь тус бүтээгдэхүүн дээр тулгуурладаг улсын санхүүд хүндрэл учруулж байгаа юм. Бодит бус ажилчдыг илрүүлснээр ойролцоогоор 11.5 сая ам.доллар хэмнэх боломжтой болох юм.

Их Британийн эрчим хүч

Их Британийн эрчим хүчний хамгийн том зургаан компанийг төлөөлдөг “Energy UK” холбоо олон жилийн турш хатуу түлшний хэрэглээг дэмжиж ирсний эцэст нүүрсээр галладаг үйлдвэрүүдийг аажмаар үйл ажиллагаанаас гаргах, оронд нь салхин болон нарны эрчим хүч зэрэг байгальд хоргүй эх үүсвэрийг ашиглахыг дэмжиж эхэллээ. Тус байгууллага ногоон эрчим хүчид үзүүлэх татаасыг бууруулсан сайд нарыг шүүмжилж байгаа аж.

Европын Холбооны зэр зэвсэг

Европын парламент өөрийн гишүүн орнуудыг Саудын Арабын эсрэг зэр зэвсгийн хориг тавихыг уриаллаа. Саудын Арабын Засгийн газрыг Йемений энгийн иргэдийн эсрэг чиглэсэн үйл ажиллагаа явуулсан хэмээн буруутгаж байгаа аж. Хэдийгээр тус саналыг хуулийн дагуу зөвшөөрөх албагүй ч хууль тогтоогчид гишүүн

улсын Засгийн газрууд зөвшөөрч, хориг арга хэмжээг хэрэгжүүлнэ хэмээн найдаж байгаа юм. Нидерланд улс уг саналыг хүлээн зөвшөөрсөн бөгөөд тус улсын парламентын гишүүд гуравдугаар сарын дунд үеэс Саудын Араб руу зэвсэг экспортохыг зогсоох шийдвэр гаргав. Йеменд үймээн эхэлснээс хойш 6000 хүн Саудын Арабын зэвсэгт хүчний гарт амь үрэгдсэн бөгөөд тэдний тал нь энгийн иргэд байжээ. Харин одоо Их Британи, Франц болон Герман улс хэрхэхийг л хүлээх үлдлээ.

Бразил-Европын холбоо


Бразил улс АНУ-ын тагнуул тандалтаас зайлсхийхийн тулд өөрийн улсыг Европтой шууд холбох усан доогуурх кабелийг барьж байна. Эдвард Сноуден АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын агентлаг Бразилын Ерөнхийлөгч Дилма Руссефф зэрэг дэлхийн удирдагчдын яриаг тогтмол чагнадгийг илчилсэн юм. 250 сая ам.доллараар үнэлэгдэж буй уг төсөл 2017 оны сүүлээр хэрэгжиж эхлэх бөгөөд технологийн тэргүүлэгчид болох Google болон Facebook-ээс дэмжлэг авах төлөвтэй байна.

Япон улсын тооллого

Япон улсад хамгийн сүүлд болсон хүн амын тооллогоор тус улсын хүн ам 2010-2015 оны хооронд нэг сая орчмоор буурсаныг харуулжээ. Тус улсын бага төрөлтийн доогуур үзүүлэлт болон хүн амын хөгшрөлт эдийн засаг, нийгмийн урт хугацааны ноцтой асуудлыг бий болгож байна. Баруун Европоос ялгаатай нь Япон улс цагаачид маш бага авдаг тул хүн амын тоог нөхөж чадахгүй байгаа аж. Одоогийн байдлаар Японы хүн амын гуравны нэг нь 65 буюу түүнээс дээш насныхан бөгөөд 2060 он гэхэд энэ тоо хүн амын 40 хувьд хүрэх төлөвтэй байна.

Малайзын Ерөнхий сайд

Малайзын Ерөнхий сайд Нажиб Разакийн банкны дансанд хэдэн зуун сая ам.доллар орсон болохыг АНУ-ын Wall Street Journal сэтгүүл мэдээллээ. Саудын Араб улсаас өгсөн бэлэг хэмээн хэлж байсан уг мөнгийг 681 сая ам.доллар хэмээн мэдэгдэж байсан ч тэрбум ам.доллараас давж буй хэмээн тус сэтгүүл баталж байгаа аж. Ерөнхий сайд Разак өөрийгөө ямар ч буруу зүйл хийгээгүй хэмээж, үүнийг хууль ёсны дагуух улс төрийн хандив гэж хэлжээ.

Бразилын авлига

Бразил улсын холбооны шүүгч Ерөнхийлөгч Дилма Руссефф болон экс ерөнхийлөгч Луис Инасио Лула де Сильва хоёрын хооронд өрнөсөн дахь ноён Лулаг өөрийн засгийн газартаа ажлуулах талаарх утасны яриаг олон нийтэд дэлгэжээ. Бразилын авлигын эсрэг хамгийн том мөрдөлтийн хүрээнд холбооны цагдаагийн алба Лулагийн утсыг чагнаж байсан аж. Лулаг Ерөнхийлөгчийн тамгын газрын даргаар томилох асуудлыг эсэргүүцэж олон жагсагч гудамжинд цугласан байна. Одоо ноён Лула Засгийн газрын гишүүн болсон тул зөвхөн Бразил улсын Дээд шүүх экс ерөнхийлөгчийг шалгаж, яллах мөн хорих эрхтэй болж байгаа юм. Руссефф Ерөнхийлөгчийн албан үүргийн хашиж эхэлснээс хойш авлигын томоохон хэргүүдэд буруутгагдаж байгаа юм.

Герман дахь хэт барууны үзэл

Германы цагдаагийн байгууллага 10 мужид нео-нацист “Цагаан Чононууд” бүлгийнхэнд нэгжлэг хийсний дүнд тус бүлгийг хориглох шийдвэр гаргажээ. Цагдаагийнхан гэнэтийн нэгжлэгээр галт зэвсэг, ухуулах хуудсууд болон мэдээллийн санг хураан авсан аж. Тус бүлэг Герман улсад 2014 оноос хойш идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа юм. Европт өрнөж буй цагаачийн хямралын улмаас Германд төдийгүй ▶

- ▶ Европын бусад оронд хэт барууны үзэл газар авах болжээ.

Сирийн дайн

ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин Оросын Сири дахь цэргийн гол хүчээ гаргах үүрэг даалгавар өгсөн бөгөөд тус зорилгодоо бараг хүрсэн хэмээн мэдэгджээ. ОХУ Сирийн Ерөнхийлөгч Башар Ал-Ассадын Засгийн газрыг дэмжих үүднээс агаарын зохилт өгөх үйл ажиллагааг эхлүүлсэн нь Сирийн Засгийн газарт Исламын улс бүлэглэл болон босогчдоос нутаг дэвсгэрийнхээ ихээхэн хэсгийг буцаан авахад том туслалцаа болсон юм. Женевт болсон дэлхийн их гүрнүүдийн уулзалтаар гал зогсоох хэлэлцээрт хүрсний дүнд ОХУ уг шийдвэрийг гаргасан байна.

Туркийн хэвлэл мэдээлэл

Шүүхийн шийдвэрийн дагуу Туркийн хамгийн том сонин Заманг төрийн хяналтад авсан боловч тус сонин төрийн хяналтад орохоос өмнөх сүүлчийн дугаартаа Засгийн газрыг буруутгаад амжжээ. Тус улсын цагдаагийн байгууллага “Заманг” сонинг дэмжигчдийг тараахын тулд нулимс асгаруулагч ашигласан бөгөөд Заманы ерөнхий эрхлэгч Абдулхамит Биличиг ажлаас нь халжээ. Төрийн хяналтад орсны дараагаар тус сонинны ихэнх сэтгүүлч ажилдаа эргэн орсон ч тэд дотоод сүлжээ, и-мэйлээ ашиглах боломжгүй болсон хэмээн жиргэв. Сүүлийн үед Туркийн Засгийн газар болон Ерөнхийлөгч Тайип Эрдоганыг сэтгүүлчдэд зүй бусаар хандаж байна хэмээн шүүмжлэх болсон.

Австралийн аалз



Австралид загас, мэлхий болон шананан хорхойгоор хооллодог шинэ төрлийн аалзыг илрүүлжээ. Уг аалзыг Колумбийн Их сургуулийн физик, математикийн профессор, Дэлхийн

шинжлэх ухааны наадмыг хамтран үүсгэн байгуулагч Брайн Грийни “Dolemedes briangreenei”-ийн нэрээр Dolemedes briangreenei гэж нэрлэсэн байна. Уг аалз түгшсэн эсвэл барьсан загасаа зөөхийн тулд усны гадаргуу дээр гаран дараагаар нь буцан усны гүн рүү шумбан орж нуугддаг байна.

Математик



Ферматийн сүүлийн теорем гэх 300 жилийн туршид нотолж чадаагүй бодлогыг Оксфордын Их сургуулийн профессор Андро Вайлс бодож чаджээ. Математикч Пиер дэ Фермат 1637 онд хэлэхдээ $x^n + y^n = z^n$ гэх тэгшитгэлд n нь хоёроос илүү бол бүхэл тоотой хариу байхгүй гэсэн юм. Вайлс 2016 оны Абелийн шагналыг 700 мянган ам.долларын хамтаар хүртсэн бөгөөд тус шагналыг математикийн Нобелийн шагнал хэмээн нэрлэдэг аж. Вайлс “Ферматын тэгшитгэлийг тайлах нь маш эртнээс л миний хүсэл байсан бөгөөд үүнийг бодож чадсанаар надад маш ихийг биелүүлсэн мэт сэтгэгдэл төрүүлж байна” гэжээ.

Туркийн аялал жуулчлал

Турк улсын аялал жуулчлалын салбарын төлөөлөгчид энэ оныг урьдчилан таамаглаж байсан хамгийн муу байж болох нөхцөл байдлаас ч хавьгүй муу жил байлаа гэсэн бөгөөд энэ жил тус салбар 12 тэрбум гаруй ам.долларын алдагдалтай ажиллах магадлалтай байна гэв. Тус улсын аялал жуулчлалын салбарт тулгарч буй асуудал сүүлийн үед Туркт болж буй террорист халдлагууд болон дипломат зөрчилдөөний улмаас мэдэгдэхүйц

буурсан Оросын жуулчдын тоо зэргээс улбаатай юм. Тус салбарын асуудал цааш хөдөө аж ахуй зэрэг бусад салбарт нөлөөлж, улс орон даяарх ажилгүйдлийн түвшинг нэмэх төлөв байна хэмээн салбарын төлөөлөгчид хэлжээ. Зөвхөн Антала хотод л гэхэд 80-100 мянган ажлын байр үгүй болох таамагтай байна.

АНУ-Кубын харилцаа

АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама Куба улсын Ерөнхийлөгч Раул Кастротой Куба улсад хийсэн түүхэн айлчлалын үеэр уулзлаа. Хэдийгээр тэд аль аль нь олон асуудал дээр өөр байр суурьтай байдгаа хүлээн зөвшөөрсөн ч, хоёр орны тэргүүн Куба улсаас эдийн засгийн хоригийг авч хаях тал дээр нэг байр суурьтай байна. Ерөнхийлөгч Обама “Хориг арга хэмжээг дуусгах болно” гэж мэдэгсэн юм. Гавана хотод хийсэн Ерөнхийлөгчийн айлчлал нь Флорида мужаас 145 км зайд орших арлын улстай харилцаагаа сэргээх гэсэн гурван жилийн оролдлогын үр дүн юм.



АНУ олон жилийн турш тус арлын улсыг хүйтэн дайны үеийн дайсан, сахалтай удирдагчдаар удирдуулсан хориотой газар мэтээр үзэж иржээ. ■

Асуудал

Чимээгүй салбар

И.ЖАРГАЛ

Монгол Улсад усны нөөцийн асуудал одоохондоо санаа зовоох түвшинд биш гэдэгтэй эрдэмтэн, судлаачид санал нэгддэг. Одоогоос 30-40 жилийн өмнө Монгол орны нутаг дэвсгэрт усны судалгаа нэлээд хийгдсэн байдаг. Гэхдээ өргөн уудам нутгийн усны хүрэлцээ хангамж харилцан адилгүй. Жишээлбэл, Хөвсгөл, Сэлэнгэ аймгийн усны нөөц дэлхийн усны дунджаас харьцангуй их. Гэтэл говийн аймгуудийнх дэлхийн дунджаас хэд дахин бага байх жишээтэй. Усны нийт нөөцийн 80 хувь нь гадаргын ус, 20 хувь нь гүний ус. Хэрэглээн дээр болохоор 80 хувь нь газрын гүний ус, 20 хувь нь гадаргын ус юм. Улаанбаатар хотын хувьд 99 хувь нь газрын гүний ус ашиглаж байгаа нь эргээд нөөц багасахад нөлөөлж байгаа юм.

Монгол баруун, төв, зүүн хэсэгт гурван том нууртай. Нэг хүнд ногдох усны нөөцөөрөө дэлхийн 182 орноос 56 дугаар байрт жагсдаг. Хэдий манай орон цэнхэр гаригаас ундаалах усаа ийн ахиу авч чадсан ч монголчууд маань усны үнэ цэнийг ойлгох тал дээр хойрго хандаж, гол мөрний бохирдол ихсэж, цаг уурын дулаарал болон уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй явагдсаны улмаас сүүлийн жилүүдэд цөөнгүй гол горхи ширгэх болсон нь аюул ойртож буйг илтгэх. Сүүлийн 30 жилийн хугацаанд 569 нуур ор мөргүй алга болж, үүнээс гурав дахин их хэмжээний гол, горхи ширгэж, хөдөө аж ахуйн хэдэн мянган инженерийн хийцтэй худаг устаж, 100 гаруй услалтын системийн барилга байгууламж газрын хөрснөөс арчигдсан гэсэн харамсалтай мэдээ байна. Үүний улмаас хөдөөд худаг усаа булаацалдаж, зодолдож талцсан байдал бишгүй бий. Гэтэл 30 жилийн өмнө усны аж ахуйн салбар хүний нөөцийн хувьд сайн, үйлдвэр, хөдөө аж ахуйн усан хангамжийн асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр шийдвэрлэдэг байжээ. Мэдээж энэ асуудлыг хариуцсан бодлого гаргадаг яамтай байсан.

Манайд ус үнэгүй шахам байгаа учраас бид үнэ цэнийг нь мэдрэх болоо-

гүй байна. Улаанбаатар хотод гэхэд л гэр хорооллын айл өрх нэг литр усыг нэг төгрөгөөр авдаг бол орон сууцны оршин суугч 30-50 мөнгөөр авч байна. Энэ нь 2014 онд нэмэгдсэн тариф юм. Монгол орны усны үнийг дэлхийн бусад улстай харьцуулсан судалгаанаас авч үзэхэд 15-100 дахин хямд байгаагаас гадна усныхаа 50 шахам хувийг төлбөрөөс чөлөөлж үнэгүй ашиглуулдаг гэсэн баримт бий. Эндээс үзэхэд манайд усны үнэ цэнийг ойлгож, усны эдийн засгийн талаар ярих цаг хэдийнэ болсон.

Манай сэтгүүлийн хувьд ногоон эдийн засгийн талаар байнга хөнддөг учраас жил бүрийн дэлхийн усны өдрөөр усны нөөц, хангамж, үнэ тарифын асуудлыг усны холбогдох байгууллагууд, эрдэмтэн, судлаачидтай хамтраад хангалттай бичиж ирсэн.

Харин энэ удаа дэлхийн усны өдрөөр НҮБ-аас “Ус ба Ажлын байр” гэсэн уриа дэвшүүлжээ. Үүнтэй холбоотой асуудлыг арай өөр өнцгөөс харъя гэж бодлоо.

Юуны түрүүнд усны сэдэв жилээс жилд дэлхий нийтэд хүрээгээ тэлж, хөгжил дэвшлийг тодорхойлох хэмжээнд хүрч байгаагай өөрийнхөө улсын усны салбарынхны дуу хоолой, ажил үйлсийг харьцуулаад үзэхээр чимээгүй салбар юм байна гэсэн тодорхойлолт толгойд зурсхийв. Яагаад ийм чимээгүй байна вэ? Харин ч их чимээтэй байхаар атал чимээгүй байх шалтгаан нь юу юм бол? Энэ дагуу усны салбарын зарим эрдэмтэн судлаачтай санал солилцож, манайд өнөөдөр устай холбоотой улсын хэмжээнд хамгийн тулгамдсан асуудал юу байна вэ гэж сонирхсон. Тэд ярилцсан юм шиг удаан бодолхийлснээ “хамгийн гол нь усны салбарт тогтсон бүтэц байх хэрэгтэй байна. Усны аж ахуйн яамтай л болох ёстой. Тэгэхгүйгээр усны тухай асуудлуудыг ярьж хэлээд хаданд хашгирч байгаа юм шиг замхарч байна” гэж цөхөрсөн шинжтэй учирласан.

Яагаад тэр вэ. Усны салбарын бодлого, шийдвэрийг дагнасан яам байх-▶



► гүй 30 жилийг үджээ. 1990 оныг хүртэл Усны аж ахуйн яам гэж байж. Өнөөдөр усны холбогдолтой асуудал сэдвээсээ хамаараад бараг яам бүрийн хавирга, бөөрөнд нь явдаг бололтой юм.

“Дэлхийн аль ч оронд усныхаа асуудлыг гаргуунд нь хаячихсан, зохистой бүтэцгүй, судалгаа шинжилгээний хүрээлэн, байгууллага ч үгүй орон манайхаас өөр байхгүй. Зарим яаманд усны асуудал хариуцсан мэргэжилтэн ажилладаг нь бодлого, бүтэц байгаа ч юм шиг, үгүй ч юм шиг. Салбарыг тамирдуулж байгаа гол хүчин зүйл нь оновчгүй удирдлагын бүтэц” хэмээн Монголын усны үндэсний холбооны тэргүүн, ШУТИС-ийн багш доктор, профессор С.Чулуунхуяг хэллээ.

Гидротехник, гидрологи, гидрогеологи, гидромелораци, ус хангамж, ус цэвэрлэгээ гэх мэт 30 орчим мэргэжлээс бүрддэг тус салбарт боловсон хүчний томоос том орон зай үүсээд буй аж. Хүний нөөц бүрдэх боломжийг ч сүүлийн хагас жаранд энэ салбарт өгөөгүй. Усны яам битгий хэл агентлаг, газар ч бий болгож тогтвор суурьшилтай ажиллуулсангүй. Тухайлбал, 2004 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч Усны

агентлаг байгуулагдсан боловч 2012 онд татан буулгажээ. Усны хүрээлэн гэж байсан ч мөн татан буугдсан. Одоо сүүлд байгуулагдсан Голуудын сав газрын захиргааг л битгий татан буулгачихаасай гэж залбирч суух үлдэж.

Жишээлбэл, усны ашиглалтын асуудал Барилга, хот байгуулалтын яаманд, нөөцийн асуудал БОНХАЖЯ-нд, хөдөө аж ахуйн усан хангамж Хүнс, хөдөө аж ахуйн яаманд, устай холбоотой хүний эрүүл ахуйн асуудал болохоор Эрүүл мэндийн яаманд гээд татан байршсан. Удаан жил ингэж олон яамны дунд нааш цааш шидэгдэн яваа нь салбарын эрдэмтэн, мэргэжилтнүүдийг үгээ хэлэхгүй цөхөрөхөд хүргэж байгаа аж. Асуудал ийн хамааралтай яамдаа харьяалагдах нь байж болохгүй зүйлгүй ч ус гэдэг өнөөдөр дэлхийн хөгжлийг тодорхойлох хэмжээний хамгийн чухал сэдэв болсон учраас салбарын эрдэмтэн, судлаачид яамтай болох ёстой гэж үзэж байгаа юм. Манай усны салбарт нөөц хангамжийн бодитой судалгаа хийгдээгүй бараг 30 жил болж байгаа гэхэд хилсдэхгүй. Усны аж ахуйн яам татан буугдахаас өмнө хийгдэж

байсан судалгааны тоонууд өнөөдөр хэдэн янзаар хэлэгдсээр аль нь үнэн гэдгийг мэдэхэд бэрх. Хоёрдугаарт, цаг уурын дулаарал бодитой явагдаж байгаа нөхцөлд чимээ аниргүй газрын гүний усаа хэрэглэсээр суух нь хэр зохилтой вэ.

Монголд усны холбогдолтой хууль, дүрэм журам хангалттай их ч хийх хэрэгжүүлэх газар нь цөөдөөд тэр үү, хүн хүч нь хүрэхгүй байна уу цаасан дээр амьдрах нь олон. Гэтэл усны асуудлыг НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уях гээд шинэ бодлого, шинэ зорилт өмнө бий. Энэ тухай хаана, хэн, юу хийж байна вэ.

Өнөөдөр дэлхий нийтэд ус ба ажлын байрны асуудал хөндөгдөж байхад манайд УСУГ 1700 ажилтныг эс тооцвол усны мэргэжилтэй залуу үе нь хаана шургалах нь тодорхойгүй. Хуучин цагт дотоод, гадаадад бэлтгэгдсэн усны мэргэжилтнүүд, хашир туршлагатай эрдэмтэн, судлаачид хаана юу хийж явна вэ. Усны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувийн компани тийм ч олон биш. Усны хүрээлэн ч алга. Гэтэл усны чанар, эрүүл ахуй гэдэг хүний алтан амьтай холбоотой асуудал хөндөгдсөөр. Бэлчээрийн усан хангамжийн асуудал зарим орон нутагт хүний амь нас хохирох хэмжээнд тийм хурцадмал болсон. Газар тариаланг хөгжүүлэх бол услахаас өөр гарц байхгүй нь сүүлийн жилүүдийн туршлагаас харагдаж байх жишээтэй. Дараагийн бодит шалтгаан бол уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр усны хомсдол үүсэх, ундны усны баталгаат чанар алдагдах, хүртээмж нь буурах, усны түвшин доошлох зэрэг асуудал. Социализмын үед дотоод, гадаадад усны мэргэжил эзэмшиж, хайгуул судалгааны ажилд хуруу хумсаа хуйхлан зүтгэж байсан эрдэмтэн судлаачдын хүчийг ашиглах хэрэггүй юу. Тэд хааяахан усны холбогдолтой хурал, семинар болохоор цуглаж, үгээ хэлдэг идэвхтэй хүмүүс. Мэдээж тэдэнд хийж бүтээх их нөөц, хүсэл эрмэлзэл бий. Тийм ч ураас усны яам байгуулахыг хүлээн суна.

Ус гэдэг цэнхэр эрдэнийн тухай дуу хоолой бөмбөрцөгт хүчээ авч, эдийн засгийн ач холбогдол нь өндөрсөж байхад Монголд хамгийн хүчгүй, чимээгүй салбар хэвээр байлгах уу?

Ус бол хөгжил. Эрчим хүчний салбарыг мөрлөн гарч ирж буй хөгжлийн шинэ нөөц. Монгол үүний хаагуур явах гэж. ■



Фотог Б.Бямба-Очир

Ярилцлага

С.Үнэн: Туул усан цогцолбор байгуулснаар усан хангамж 50-100 жилээр баталгаажина

И.ОТГОНЖАРГАЛ

Жал бүрийн гуравдугаар сарын 22-нд болдог Дэлхийн усны өдөртэй холбоотой Ус сувгийн удирдах газар /УСУГ/-ын дарга С.Үнэнтэй Улаанбаатар хотын усан хангамж, шугам хоолойн засвар, Туул усан сан цогцолбор, Төв цэвэрлэх байгууламжийн тухай ярилцлаа. Эрчим хүчний чиглэлийн мэргэжилтэй тэрбээр 2012 оны сонгуулийн дараа УСУГ-ын даргаар томилогдсон бөгөөд мөн Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал/НИТХ/-ын тэргүүлэгч гишүүний албатай юм.

Түүнтэй уулзахаар очиход Нийслэлийн Захирагч Э.Бат-Үүл болон Улаанбаатар хотын ерөнхий менежер Б.Бадрал нартай байгуулсан 2015 оны ажил үүргийн гэрээний биелэлтээ дүгнүүлж, 2016 оны зорилтынхоо талаар танилцуулж гарч ирээд байсан юм. Нүүрэндээ инээмсэглэл тодруулж гарч ирсэн тэрбээр “Хотын холбогдох удирдлагуудаас өнгөрсөн оны гэрээний биелэлтээ бүрэн хангалттай буюу 94 хувьтай онц дүнтэй биелүүлсэн гэсэн үнэлгээ авлаа” гэв. Ингээд түүний ярилцлагыг сонирхуулья.

-Дэлхийн усны өдөр жил бүрийн гуравдугаар сарын 22 гэсэн нэг л өдөр байдаг атал манай Монголд яагаад гуравдугаар сарын 22-ноос зургадугаар сарын 22 хүртэл гурван сарын хугацаатай тэмдэглэдэг уламжлалтай юм бэ?

-Дэлхийн усны өдөр уг нь бол ганц л өдөр байдаг. Үүнийг бид усны зөв зохистой хэрэглээг сурталчилан таниулах зорилгоор гурван сарын аян болгож зохион байгуулдаг. Ингэснээр иргэдэд хүрэх хүртээмж, ойлголт нь өндөр байдаг.

-Энэ удаа танай газраас усны аяны хүрээнд ямар ажлууд хийхээр төлөвлөсөн бэ?

-Гурван сарын аяны төлөвлөгөөгөө гаргасан байгаа. Зарим сонирхолтой



байж болох ажлаас дурдвал 22-ны өдөр манай УСУГ, ОСНААУГ-аас 154 хүн гаргаж 120 сургууль дээр нэгэн зэрэг усны тухай хичээл заана. Жишээ нь би гэхэд л нэг сургууль дээр очиж хичээл заах нь байна. Мөн бид жил бүрийн дөрөвдүгээр сард Туул голыг тахиж аргадах Дүлцэн залах / өргөл өргөх, голыг аргадах заншил/ ёслол хийдэг уламжлалтай. Хар усан тохойн ундны усны эх үүсвэрийн цэг дээр ном хурдаг. Гандантэгчинлэн хийдийн тэр өдрийн хуралдааны зардлыг даагаад, лам нарыг хооллож ундална. Энэ бол уух ус маань ариун тунгалаг байхыг бэлгэдэж гол усаа тахиж байгаа гэсэн үг. Түүнчлэн JCI залуучуудын байгууллагатай хамтарч 22-нд усны форум зохион байгуулна. Ерөнхий боловсролын сургуулиудын дунд нийтлэл, гар зургийн уралдаан зарладаг уламжлалтай. Японы ЭСЯ-тай хамтарч УБ хотын ус хангамжид Япон улсын оруулсан хувь нэмрийг тодруулж хэлцүүлэг зохион байгуулна. Гэх мэтээр гурван сарын хугацаанд өрнөх цаг хугацаа, мөнгө зарцуулах олон ажил төлөвлөжээ.

-Ухаалаг ус түгээгүүр гэдэг үг би сая танай байгууллагын мэдээллээс олж уншлаа. Энэ ямар учиртай юм бол.

-Их чухал зүйл олж харсан байна. Гэр хорооллын худгуудад ус түгээгч ажиллуулахгүйгээр картын системд шилжүүлж байгаа. Ус түгээгүүрийн байруудад ухаалаг технологи нэвтрүүлж байна гэсэн үг. Айл бүхэн ус түгээгүүрийн карттай байх юм. Карт хэрэглэснээр нэг талаасаа мөнгө төгрөг хураахгүй учраас усны аюулгүй байдал дээшилнэ. Хамгийн гол ач холбогдол нь хэрэглэгчид худаг хаахаас өмнө амжиж усаа авах гэж яарах шаардлагагүй болно. Манай ус түгээгүүрийн байрууд өдөр бүр 10.00-19.00 цаг хүртэл ажилладаг. Ажил албатай, ялангуяа залуу гэр бүлүүдийн хувьд усаа авч амжихгүй, усгүй хонох нь бий. Тэгвэл одоо тийм асуудалгүй, шөнийн 03 цагт ч очоод худагас ус авч болно.

-Маш сайхан мэдээ байна. Хэзээ нээс хэрэгжих вэ?

-Эхний 20 ус түгээгүүрийн байранд нэвтрүүлээд, туршилт явж байна. Энэ онд бид 100 нэмж оруулна. ▶

► **-Улаанбаатар хотын усан хангамж, нөөц ямар байгаа вэ. 2020 оноос Улаанбаатарын цэвэр усны нөөц хомсдох нь гэсэн судалгаа гарсан байдаг. Энэ тал дээр ямар ажлууд хийгдэж байна вэ?**

-Улаанбаатар хотын хувьд дан ганц гүний цэнгэг усаар хэрэглээгээ хангаж ирсэн. Цаашид энэ байдлаараа явах юм бол 2020 он гэхэд Улаанбаатарын цэвэр усны нөөц хомсдоно гэсэн судалгаа гарсан байдаг. Ингэхгүйн тулд Туул гол дээр далан барьж, усан сан байгуулах замаар Улаанбаатар хотын усан хангамжийг шийдэх нь зүйтэй юм гэж яриад багагүй хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд Туул гол дээр усан цогцолбор байгуулахтай холбоотой усны салбарын дотоодын болон гаднын эрдэмтэн судлаачдын хийсэн судалгаа ч хангалттай байдаг. Гэхдээ өнөө болтол ТЭЗҮ хийгдээгүй ирсэн. Судалгаанаас харахад Туул голын 6-7 газарт усан сан байгуулах боломжтой. Би бол үүний ядаж сайн судлагдсан гурав дээр нь усан сан барих ёстой гэж хардаг. Сүүлийн жилүүдэд цаг уурын өөрчлөлттэй холбоотойгоор нийслэлийн ундны усны эх үндэс болсон Туул гол татарч, энэ тэндээ тасардаг болсон нь Улаанбаатар хотын усан хангамж эрсдэлд орох нөхцөл үүсэж байгааг илтгэж байна. Ингээд 2014 онд ҮАБЗ Туул голын усан цогцолборын асуудлыг шийдэх нь зөв юм байна, ТЭЗҮ хийх шаардлагатай гэдэг чиглэл өгөөд, мөн Засгийн газар, Нийслэлийн мөрийн хөтөлбөр зэрэгт тусан байсан.

-ТЭЗҮ-ийг БНСУ-ын компани хийж байгаа гэж сонссон. Шаардлагатай хөрөнгийг нь хэрхэн шийдвэрлэв. Одоо ямар шатандаа явна вэ?

-Засгийн газрын зүгээс усны үнэ тарифыг 2014 оны долдугаар сарын 15-нд өөрчилсөн. Тэрүүгээр тодорхой хэмжээний хөрөнгө төвлөрсөн. Энэ хөрөнгийг Нийслэлийн зүгээс татвар болгож авах биш УСУГ-т Туул голын усан цогцолборын ТЭЗҮ-ийг санхүүжүүлж, уг ажлыг зохион байгуулах чиглэл өгсөн. Манай УСУГ алдагдалтай ажилладаг байгууллага. Гэхдээ алдагдалтай ажилладаг гэдгээрээ нийгмийн өмнө тулгарсан том асуудлыг шийдэхгүй явах эрх бидэнд байхгүй. ТЭЗҮ-д шаардлагатай 6.8 тэрбум төгрөгийг 2015 оны төсөвт

3.0 тэрбумыг, 2016 оны төсөвт 3.8 тэрбумыг шат дараатай суулгасан.

Туул усан цогцолборын ТЭЗҮ-ийг хийх сонгон шалгаруулалт зарлаж, эхний шатанд 15 компани оролцож Хятад, Солонгос, Монголын гурван компани үлдсэн. Түүнээс Хятадын компанийн үнийн санал нэлээд өндөр байсан. Үлдсэн Солонгосын “Yooshin engineering”, Монголын “Пристеж” компанийн консорциум шалгарсан. “Yooshin engineering” Солонгос улсдаа төдийгүй олон улсад танигдсан туршлагатай компани. Бид мэднэ, Солонгос улс маш олон усан боомтой. Тэрний ихэнхийнх нь зураг төслийг энэ компани хийсэн. Манай Барилга, хот байгуулалтын яам, БОАЖЯ, Ус сувгийн газрын төлөөлөгчдөөс бүрдсэн баг Солонгост очиж тус компанийн барьсан усан боомтуудтай танилцаж, туршлага судалсан. Монголын компани туслан гүйцэтгэгчээр ажиллаж байгаа. Өнөөдрийн байдлаар ТЭЗҮ бэлэн болоод байна. Эцсийн байдлаар ажлын зураг төсөл бэлэн болохоор нь Засгийн газарт өргөн барина.

Туул усан цогцолборыг байгуулснаар хөрсний ус, гадаргын усан хангамж хосолмол хэлбэрээр явна. Ийн гадаргын усан хангамж руу шилжсэнээрээ Улаанбаатарын усан хангамж 50-100 жилээр баталгаажина.

-Төв цэвэрлэх байгууламжийн асуудал хэрхэн шийдэгдэхээр байна. Одоо ажиллаж байгаа цэвэрлэх байгууламжийн үнэрийг дарах мөн шинээр барих гээд хоёр ажил байгаа. АСЕМ-аас өмнө тус байгууламжаас гарч байгаа эвгүй үнэрийг дарж чадах болов уу?

-Өнгөрсөн оны зургадугаар сард манай газраас Төв цэвэрлэхэд аваарын засвар хийсэн. Дараа нь аравдугаар сарын 17-нд УСУГ-ын даргын тушаал гарч, Онц байдал зарласан. Авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаад, хугацаа, хөрөнгө тавиад үнэр дарах туршилтууд хийгдээд явж байна. Ерөнхий сайд ч газар дээр нь ажиллаж, энэ асуудлыг маш сайн ойлгож, Засгийн газраас 8.1 тэрбум төгрөгийн хөрөнгө шийдэж өгсөн. Хотын ерөнхий менежер Ц.Бадралаар ахлуулсан Ажлын хэсэг ажиллаж байна. Хугацаа тун бага байна. АСЕМ-ийн үеэр үнэр дарагдсан байх эсэхийг одоохондоо хэлж мэдэхгүй. Дарахын төлөө миний бие ч гэсэн сэтгэл гарган ажиллаж

байна.

-Шинээр барих цэвэрлэх байгууламжийн асуудал ямар шатанд байна вэ?

-ҮАБЗ-ийн Төв цэвэрлэх байгууламж барих ажлыг яаравчилах тухай зөвлөмж гарсан. Концессын гэрээгээр барьж шийдэх ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгийн эхний хуралдаанаар тендер зарлаж 11 компани саналаа ирүүлсэн. Эхний шатны шалгаруулалт буюу богино жагсаалтаа хийсэн. Үүгээр таван компанийг шалгаруулсан. НХОГ, УСУГ-ын захиалгаар хийгдсэн ТЭЗҮ-ийг гардуулж өгсөн. Шийдлээ гаргаад, үнийн саналаа боловсруулаад саналаа ирэх дөрөвдүгээр сарын 17-ны дотор ирүүлнэ. Бид тэрийг нь үнэлнэ. Шалгарсан компанитай гэрээ хийнэ.

Энэ миний ярьж байгаа шиг ийм амархан бүтчих ажил биш. Компаниуд Засгийн газраас баталгаа шаардаж байгаа. Концессоор хийхээр компаниуд банкуудаас зээл авна. Тэр баталгааг Засгийн газар гаргаж өгөх боломж өнөөдөр хумигдмал. V цахилгаан станцын төсөл баталгаа шаардсан. 10 жил яригдаж байна. Одоо эхлээгүй л байна. Концесс өөрөө ийм зовлонтой. Дээрээс нь 2-3 муу талтай. Хяналт шалгалтгүй хийгддэг учраас ажлын чанар тааруухан болдог. Барьж—ашиглаад—шилжүүлэх болохоор үнэ тарифыг асар өсгөдөг. Энэ тооцоог нь хийлгээд үзэхээр иргэдийн нуруун дээр одоо байгаа үнэ тарифаас бараг 27 дахин өндөр үнэ мөрдүүлэх шаардлагатай юм билээ.

-Энэ тал дээр мэргэжлийн байгууллагын удирдлагын хувьд таны байр суурь ямар байгаа вэ?

-УСУГ-ын зүгээс үүнийг хөнгөлөлттэй зээлээр хийх ёстой гэж үзэж байгаа. Нэгдүгээрт, ажил чанартай байна. Мөн богино хугацаанд хийнэ. Гуравдугаарт, үнийн хувьд хөөрөгдөл үүсэхгүй. Мэдээж хэрэг зардал, тариф жаахан өсөх байх. Шинэ байгууламж бариулсан юм чинь тодорхой хэмжээний мөнгө гарч л таараа.

-Шинэ цэвэрлэх байгууламжийн ТЭЗҮ-ийг хийсэн гэсэн. Хаана, хэр хүчин чадалтай байгууламж барих вэ?

-Одоогийн төв цэвэрлэх байгууламжийн хажууд барина. 2030 оны түвшинд өсөн нэмэгдэх хэрэглээндээ тохируулсан тийм хэмжээний цэвэрлэх байгууламж барина гэвэл 600, 700 сая

▶ доллар шаардлагатай болно. Тийм болохоор бид эхний ээлжинд одоогийн хэрэглээндээ таарсан байгууламж барья. Тэрийгээ ашиглалтад орохоор хуучныгаа сайжруулж авна. Францын компани маш сайн ТЭЗҮ хийсэн. Одоо ажиллаж байгаа цэвэрлэх байгууламж хоногт 200-гаад мянган шоо метр бохир ус таган цэвэрлэх хүчин чадалтай. Шинээр барих нь 250 мянган шоо метрийн хүчин чадалтай байх юм. Нийлээд 450 мянган шоо метр усыг цэвэрлэх хүчин чадалтай болно. Энэ нь ойрын 50 жилдээ бол боломжийн.

-Шугам хоолойн шинэчлэл рүү орж чадах нь уу?

-УСУГ шинээр дуудлагын нэгдсэн төв байгуулсан. Энэ төвд маш их гомдол ирдэг. Зонхилох гомдол нь крантны ус зэвтэй гоожиж байна, өнгө, үнэр амттай гарч байна гэдэг. Энэ маань шугам хоолой муудсаных. Манай цэвэр усны шугам хоолойнууд 1959 оноос хойш өдгөө 50 гаруй зарим нь 60-аад жил болсон байна. Хэдийгээр бид газрын гүнээс сайн ус олзворлоод, шахаж байгаа боловч иргэдэд хүрэх замдаа эрсдэлтэй болж байна. Тиймээс шугам хоолойгоо засварлах шаардлага бий. Засгийн газар Австрийн засгийн газраас Улаанбаатар хотын цэвэр усны шугам хоолойг сайжруулах чиглэлээр 7.0 сая еврогийн хөнгөлөлттэй зээл авахаар зээлийн гэрээ хийгдэж байна. Нэн тэргүүнд солих шаардлагатай буюу хамгийн муу гэгдэж байгаа нь нийт шугам хоолойн 10 хувь байдаг. Тэрийг дээрх хөрөнгөөр шугам доторлогооны аргаар сайжруулна. Хамгийн гол нь энэ төслийг хэрэгжүүлснээр бид технологи өвлөж авах юм. Нэг үгээр хэлбэл, шугам доторлодог технологийг, тоног төхөөрөмжтэй нь суралцан өвлөж авна. Ингэснээрээ цаашид Ус сувгийн удирдах газар өөрөө шугам хоолойгоо засварлах бололцоотой болох юм.

-Тэгвэл нэлээд том засварын ажил явагдах нь ээ. АСЕМ болоод засвар хийх бололцоо гарах уу?

-Газар ухааж, шугам хоолойнуудыг гаргахгүй. Ус, бохир, цахилгаан, дулааны шугам засварлахаар хэцүү шүү дээ. Газар ухааж шороо овоолоод, дээрээс нь цахилгааны шугам, холбооны шугам таслана, зам хаагаад бөөн төвөг болдог. Бид тэгэхгүй, хоёр худаг хооронд шугамыг өөрийг нь доторлодог тусгай технологи

ашиглана.

-Улаанбаатар хотын ундны усны аюулгүй байдал тал дээр юу хийж байгаа вэ?

-УСУГ өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд маш том нэг ажил хийсэн. Ундны усны аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн журам зааврууд. Журам заавартаа гол нь биш, “Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө” гэж хийсэн. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр. УСУГ-ын 125 мэргэжилтний баг ажиллаж бүх үйл ажиллагааг үнэлсэн. Гэр хороололд тэргэн дээр саваа түрж очоод, худгаас усаа аваад гэртээ очих хүртэл ундны усанд аюулгүй байдлын ямар эрсдэл үүсэж болох вэ, газрын гүнээс асар их эрчим хүч, насос ажилуулж, олон хүний хүч хөдөлмөөр гаргаж аваад, усан санд хуримтлуулж ариутгаж халдваргүйжүүлдэд орон сууцны айлын усны цоргонд хүргэж буй усанд ямар аюулгүй байдал үүсэж болох вэ гэдэг хэмжээнд нь хөрсний бохирдол, нөөцийн асуудал, шугам хоолойн зэв, бүх асуудлыг багтааж үнэлсэн. Төлөвлөгөөгөө бид тусгай хөтөлбөр болгоод 27 тэрбум төгрөгөөр санхүүжүүлж байж Улаанбаатар хотын ундны ус иргэдэд аюулгүй хүрэх зорилтыг хангах юм гэсэн праграмм болгосон. 2017, 2018 он хүртэл аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр болсон. 74 эрсдэлийг тооцоолоод 176 хариу арга хэмжээнүүдийг төлөвлөсөн байдаг. Үүнийг ДЭМБ маш өндрөөр үнэлсэн. Адил хөтөлбөр боловсруулж байгаа орнууд дотроос Улаанбаатарын УСУГ-ын хийсэн төлөвлөгөө маш богино хугацаанд үр дүнтэй болсон гээд өөрийн тайландаа оруулсан. Манай хөтөлбөрийн үндсэн дээр одоо 21 аймаг өөрсдийн усны төлөвлөгөөг боловсруулж байна. Аймаг бүрт боловсруулах багийг бий болголоо. Сургалт арга зүйгээр хангаж, 21 аймагт хүмүүсээ явууллаа. Энэ бол манай ажил биш, улсын хэмжээний ажил. Гэхдээ манайх зөвхөн Улаанбаатар хотынхоо л асуудлыг шийдэх ёстой гэж суугаагүй. Мөн нийгмийн хариуцлагатай компанийн хувиар хандсан.

-Байгууллагынхаа 2015 оны зорилтот түвшний ажлын төлөвлөгөөнөөсөө товч сонирхуулахгүй юу. Тухайлбал усны үнэ тарифийн хувьд ямар байх вэ?

-Би дээр 2015 оны контракт гэрээгээ 94 хувьтай буюу бүрэн хангалттай онц гэж үнэлүүлсэн талаар ярьсан. Тэгэхээр энэ амжилт бол манай УСУГ-ын 1700 хүний хичээл зүтгэл, ажлын үр дүн юм.

Гэрээнд 2016 онд олох орлого, зарлага, хүлээх алдагдлыг тусгасан. Энэ онд манай байгууллага 10-15 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллах нь. Ус суваг 130 тэрбум төгрөгийн өртэй байна. Жилдээ 15 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилладаг. Гаргаж байгаа бүтээгдэхүүнийхээ үнийг зохистой түвшинд буцааж авч чаддаггүй байна. Нэг үгээр хэлбэл, үнэ тарифыг Засгийн газар чөлөөлөхгүй байна.

130 тэрбум төгрөгийн өр яагаад үүссэн бэ гэхээр Төв цэвэрлэх байгууламж дээр Испанийн вант улсын зээл авсан байдаг. 2000 оноос өмнө тоног төхөрөмөж тавьж шинэчлэл хийсэн. Дараагийнх нь Нийтийн аж ахуйг сайжруулах I, II төсөл гэж гэр хорооллын усан хангамжид зориулсан хоёр төсөл байдаг. Энэ хоёр төслийн үр дүнд манайх ийм өндөртэй болсон ба маш их алдагдал хүлээж байгаа. Дээр нь бид гэр хороололд найман төгрөгийн зардал гаргаж ус хүргэж өгөөд, нэг төгрөгөөр борлуулдаг. Энэ онд гэр хорооллын цэвэр усан дээр 11 тэрбум төгрөгийн алдагдал хүлээх нь ээ. Тэгэхээр бид өнөөдөр яах ёстой вэ гэхээр үнэ тарифаа шийдүүлэх хэрэгтэй байгаа. Байгууллага санхүү эдийн засгийн хувьд баттай зогсож байж иргэдэд найдвартай, зөв үйлчилгээ хүргэнэ. Аюулгүй, өндөр чанартай ус хүргэх учиртай.

Аливаа бүтээгдэхүүний үнэ өөрийн зардлаа ашигтайгаа шингээсэн байдаг. Усны үнийг барих нь УСУГ-ыг хөгжил дэвшлийг боогдуулж байна, өрөнд оруулж байна. Цаашдаа ажиллах нөхцөлгүй болгоно гэсэн үг. Энэ бүхнээс салахын тулд үнийн бодлогыг зөв болгох хэрэгтэй. Үнэ дотор байгууллагын том өрүүд, Засгийн газрын өөр орноос зээлж манай салбарт хөрөнгө оруулалт болгосон өрийг төлөх хэрэгтэй болно.

-Үнийг хэдэн төгрөгт байлгавал таны ярьж байгаа асуудал шийдэгдэх вэ?

-Үнэ тарифыг би эхний ээлжинд хотод нэг үнэ мөрдөх хэрэгтэй гэж бодож байгаа. Усны тухай хуульд тухайн суурин газрын хэрэглэж ▶

► байгаа усанд нэг үнийн тариф мөрдөнө гэсэн ухагдахуун байдаг. Одоо бол алслагдсан айлуудад усыг хоёр төгрөгөөр, гэр хороололд нэг төгрөгөөр, орон сууцанд 45-50 мөнгөөр зарж байна, үйлдвэрүүд гэхэд дотроо арьс ширний болон ус их хэрэглэдэг гээд баахан ялгавартай үнэ мөрдөгддөг. Монгол хүн гэр хороололд амьдарснаараа орон сууцны иргэдээс илүү үнэтэй ус ууж таарахгүй. Эхний ээлжинд үнийг шударга тогтоох. Уг нь бол гэр хороололд нэг төгрөг биш 10 төгрөг байх ёстой. Ийм мөнгөөр ус авах иргэн гэр хороололд байхгүй. Хэдийгээр нийслэлийн хүн амын ихэнх нь гэр хороололд амьдарч байгаа ч усны хэрэглээгээрээ орон сууцныхан гэр хорооллынхоос 20 дахин илүү ус хэрэглэдэг. Тийм учраас 20 дахин илүү ус хэрэглээд байгаа сектор рүү үнийн бодлогоо чиглүүлэх ёстой. Ядаж орон сууцны үнийг нэг төгрөг болгох хэрэгтэй байна. Цаашлаад хоёр,

гурван төгрөг гээд гэр хорооллын үнээ дагаад явах ёстой. Нэг литр усны үнэ хэд байх вэ гэдгийг өнөөдөр Үнэн миний бие шууд хэлчихдэг юм биш ээ. Улс орны эдийн засаг, инфляцийн түвшин, ард иргэдийн амьжиргааны түвшин, гаргаж байгаа зардлууд гээд олон зүйлийг тооцож гаргах болно. Тэр битгий хэл, Төв цэвэрлэх, Туул усан цогцолборыг барих уу, барих бол хаанаас мөнгө гаргах вэ гэдэг асуудал ч энэ үнэ тооцож гаргахад хамаатай.

-Танай байгууллага бараг 2000 дөхсөн ажилтантай байна. Усны үнийн асуудлаас болоод алдагдалтай ажилладаг. Ажилтнуудынхаа нийгмийн асуудалд хэр анхаарч чаддаг вэ?

-Ажилтнуудынхаа нийгмийн асуудлыг сайжруулах тал дээр нэлээд хичээж ажиллалаа. Манайх 2014 оны арваннэгдүгээр сард цалингаа 15 хувь нэмсэн. Өнгөрсөн оны тавдугаар сард 15 хувь нэмсэн. Эдийн засгийн нөхцөл


байдлаас шалтгаалаад олон хувийн байгууллага хаалгаа барьж байна. Олон төсвийн байгууллага цалингаа тавьж чадахгүй байна. Энэ тал дээр УСУГ амжилттай байсан гэж хэлнэ. Дээрээс нь бид ажилчиддаа 180 айлын орон сууц барьж байна. Ажилчдын эрүүл ахуй, хувцас хангамж дээр олон зүйл төлөвлөөд мөнгө зарж байгаа. Энэ бүхэнд зарцуулж байгаа мөнгө хангалттай хэмжээнд биш. Ус суваг өөрөө алдагдалтай ажилладаг учраас олон ажил хийх хэрэгтэй байна.

Эцэст нь хэлэхэд, хотын унаган иргэн, НИТХ-ын тэргүүлэгч гишүүн, УСУГ-ын даргын хувьд хот маань хот шиг хот байгаасай. Хүний таатай амьдрах орчин байгаасай, иргэд маань аз жаргалтай сайхан байгаасай гэж хүсдэг. Түүнд ус нөлөөтэй. Үүнд оруулах миний хувь нэмэр энэ юм. Өнгөрсөн хугацаанд ийм л санаа бодолтой ажиллалаа, ойрын ажлаа ч ингэж төлөвлөж байна. ■

Ус хэрэглэгчдэд хэрхэн хүрдэг вэ?



Улаанбаатар хотын усны нөөц




Зургаан эх үүсвэрээсээ хоногт **155-160** мянган шоо метр усыг олзворлож хэрэглэгчдийг цэвэр усаар хангадаг

Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хот нь усны нөөцийнхөө **54%** -ийг хэрэглэж байна

Улаанбаатар хот нь унд ахуйдаа гүний ус хэрэглэдэг ба гүний усыг зургаан эх үүсвэрээр олзворлож байна

Цэвэр усны эх үүсвэр нь гадаргуун болон гүний усны 2 төрөлд хуваагдана. Гадаргуун эх булагт нуур, цөөрөм, далай тэнгис, гол горхи. Гүний эх булагт хөрсний болон гүний ус орно.

Ус олзворлон түгээх явц дахь алдагдлын хэмжээ сүүлийн 5 жилд




Манай орны хот суурины усан хангамжид гүний эх булгийн усыг өргөн ашигладаг.


Эх үүсвэр гэдэг нь гүний эх булгаас ундны усыг олборлох тусгай хамгаалалтын бүс бүхий байгууламж юм.

Гүний эх үүсвэрийн барилга байгууламжид гүний худаг буюу 1-р өргөгч станц, 2-р өргөгч насос станц, усан сан хлоржуулах байгууламж багтдаг.

Шугамаар хангагдаж байгаа ус түгээх байрны нэг оршин суугчийн хоногийн хэрэглээ /литр



Зөврөөр хангагдаж байгаа ус түгээх байрны нэг хүний хоногийн хэрэглээ



Усны нөөц

Мөрөөдөл ойртох цагаар

Г.ОРХОН

Дөрөвхөн жилийн дараа хот даяараа ангаж цангахын зовлонг мэдэрч эхэлнэ. Учир нь нийслэлчүүдийг өнөөдөр ганцхан гүний усаар тэтгэж буй. Харин энэ нь ирээдүйн баталгаа болж чадах уу.

Салбарын яамны мэргэжилтнүүдийн тооцоолсноор 2020 он гэхэд нийслэлчүүдийн усны хэрэгцээ хамгийн багадаа жилийн 100 сая шоо метрт хүрнэ. Энэ нь газрын доорх усны ашиглаж байгаа одоогийн нөөцтэй дүйж байгаа юм. Харин усны хэрэглээг ихээр тооцоход дээрх босгыг илт давж 160 сая шоо метрт хүрч одоогийн ашиглалтын нөөц хүрэлцэхгүй болох нь.

Монгол Улс нийслэлийнхээ гүний усны ашиглалтын нөөцийг өнгөрсөн онд шинэчлэн тогтоосон бөгөөд хоногийн 270 орчим мянган шоо метр гүний усны ашиглаж болох нөөцтэй хотод бид амьдарч байна. Гэтэл 2030 онд зөвхөн ахуйн усны нийт хэрэглээ л гэхэд хоногт 310 мянга гаруй шоо метр болох нь. Үүн дээр үйлдвэр, аж ахуйн хэрэглээ нэмэгдэнэ гээд бодохоор одоогийн нөөц хотын усны хэрэглээг бүрэн хангах боломжгүй болж бидэнд шинэ эх үүсвэр хэрэгтэй болж байгаа юм.

Бусад хотын хувьд өдгөө манайд тулгараад буй ус хангамжийн асуудлыг боомт барьж шийддэг сайн туршлага бий. Энэ нь гүний болон гадаргын усыг хослуулан хэрэглэнэ гэсэн үг. Монгол Улс энэ тухай ярихгүй биш 30 гаруй жил үглэсэн ч уг боомтыг хаана барихаа өдийг хүртэл шийдээгүй явна. Ямар ч гэсэн олон зориулалттай боомт барих нь хамгийн тохиромжтой, эдийн засгийн хувьд боломжтой хувилбар гэдэгт санал нэгдэж гараанаасаа гараад байна.

Ийн байгуулах гэж буй боомтоо “Туул усан цогцолбор” хэ-

мээн нэрийдэж төслийн техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-ийг БНСУ-ын “Yooshin Engineering”, Монголын “Престиж” компани хамтран хийж байна. Тус цогцолборыг барьснаар гадаргын болон гүний усны нөөцөөр хотын ус хангамжийг шийдвэрлэх, Туул голын экологийн урсацыг тогтвортой болгож, урсацын хэмжээг буурахаас сэргийлнэ. Мөн усан санд хуримтлагдсан усыг ашиглан эрчим хүч үйлдвэрлэх, аялал жуулчлал, усан спортыг хөгжүүлэх зэрэг эерэг талтай гэж үзэж байна.

ТЭЗҮ-ийг хийж буй “Yooshin” компанитай холбогдох газрууд өнгөрсөн оны есдүгээр сарын 10-нд гэрээ байгуулсан бөгөөд үүнээс хойш сарын хугацаанд тэд ажлаа эхэлжээ. Солонгос улсад ус хангамж, газар тариалан тэргүүтэй төрөл бүрийн зориулалттай 30 мянга гаруй боомт байдаг бөгөөд дийлэнхийнх нь ТЭЗҮ-ийг боловсруулах, зураг төсөл, барилгын ажил дээр эл компани оролцсон туршлагатай аж.


Тус компанийнхан Улаанбаатар хотод усан цогцолбор барих талаарх урьд нь хийсэн судалгааны ажлууд дээр үнэлэлт дүгнэлт хийх, түүнд тулгуурласан тооцоо судалгаа гаргаж ТЭЗҮ-ийг эхний байдлаар боловсруулаад байгаа юм. Туул гол дээр боомт барихтай холбоотой гидрологийн судалгаа, шинжилгээ манайд хангалттай сайн хийсэн байдаг.

Гагцхүү ТЭЗҮ боловсруулах тал дээр дотоодын хөрөнгө хүч хүрэхгүй олон жил ярьснаас цаашгүй явсан аж. Харин УСУГ-аас ТЭЗҮ хийлгэхээр шаардлагатай хөрөнгийг зориглон гаргаж, хийлгүүлж буй юм. ТЭЗҮ-ийн нийт өртөг 6.8 тэрбум төгрөг. Өнгөрсөн сарын 25-нд төслийн эхний хэлэлцүүлэг болж “Yooshin” компанийнхны гаргасан ТЭЗҮ салбарын мэргэжилтнүүдээс багагүй шүүмж сонсов.

БОНХАЖЯ-ны ахлах мэргэжилтэн Ч.Пунцагсүрэн “ТЭЗҮ-ийг гаргах хугацаанд нийт дөрөвхөн газар өрөмдсөн байна. Нэг газрыг хоёрхон өрөмдөөд бүх зүйлийг нь мэднэ гэж байхгүй. Олон улсын стандартын дагуу доод тал нь 20 метр тутамд өрөмдлөг хийсний үндсэн дээр нарийн тооцоо гарч ирнэ” хэмээсэн. Гэтэл ажлын даалгаварт хөндлүүр тус бүрт 2-3 кооног өрөмдөнө гэж заажээ. Энэ талаарх “Yooshin” компанийн байр суурийг авах гэсэн ч тэд одоогоор визээ сунгуулахаар нутаг буцаад байгаа аж. Харин УСУГ-ын Техникийн шинэчлэлийн төсөл хариуцсан мэргэжилтэн С.Хишигжаргалын /Тэрбээр “Туул усан цогцолбор” төслийн ажлын даалгаврын боловсруулахад оролцсон/ хэлсэнээр ТЭЗҮ-д дурьдсан гурван байршлын эхний хувилбар буюу хөндлүүр нэг дээр 2012 онд хоёр кооног өрөмдсөн байж. Тиймээс үлдсэн хоёр газарт тус бүр хоёр кооног өрөмджээ.

Салбарын зарим мэргэжилтэн хийгээд яамны зүгээс ажлын даалгаврын дагуу ТЭЗҮ-ийг хийгээгүй гэж шүүмжилсэн. Харин үүнд С.Хишигжаргал “Компани арай өөр хэлбэрээр танилцуулгаа бэлтгэсэн учир үл ойлголцол гарсан. Одоо хийсэн ажлуудаа ажлын даалгаврын дагуу танилцуулахад бэлтгэж байгаа. Компани сонгон шалгаруулалтад оролцохдоо ажлын даалгавартай танилцаж, ТЭЗҮ-ийг уг даалгаврын дагуу хийдэг учир огт танилцаагүй гэдэг нь өрөөсгөл ойлголт” гэсэн тайлбар өгөв.

Хэлэлцүүлгийн эцэст тус компанийг ТЭЗҮ-ээ ажлын даалгаврын дагуу хийх, ингэхдээ мэргэжилтнүүдийн санал, зөвлөмжийг тусгаж, судалгааны эцсийн хувилбарыг гүйцэтгэгч компанийн хүсэлтийн дагуу тодорхой ▶



▶ хугацаанд сунгаж гаргахаар болсон. Одоогоор “Yooshin” компанийнхан үүний дагуу ажлаа хийж байгаа аж. Ямартай ч ирэх сарын эхээр ТЭЗҮ-ээ батлуулчихвал дараагийн ажлууд эхлэх гэнэ. Өөрөөр хэлбэл, ажлын даалгаврын дагуу илүү нарийвчилсан судалгаа, тооцоо хийх юм.

1980-аад оноос хойш хийсэн ОХУ-ын эрдэмтдийн судалгаагаар Туул, Тэрэлжийн бэлчирээс доош гурав, Тэрэлж гол дээр хоёр нийт таван хөндлүүр сонгосон байдаг аж. Хөндлүүр гэдэг нь боомт барих боломжтой газар. “Yooshin” компанийнхны сонгосноор эдгээрээс хамгийн тохиромжтой нь Гачууртын дээд талын Хар усан тохой орчмын газар. Усны салбарынхан үүнийг гуравдугаар хөндлүүр гэж нэрлэж. Уг хэсгийн усан хангамжийн хүчин чадал нь 2040 оны түвшинд Улаанбаатар хотын хэрэглээг хангахад дөхөж очно гэж үзэж байна. Энэ газарт усан цогцолбор барихад нийт 400 сая ам.долларын хөрөнгө шаардлагатай нь ч ТЭЗҮ-ээр гарчээ. Харин боомтын барилгад сүүлийн үед олон улсад түлхүү хэрэглэж буй “RCC” буюу цахилгын станцын үнсийг ашиглах технологиор барих тухай ажлын даалгаварт санал болгосон ч тэдний үзэж буйгаар Монголын нөхцөлд цемент, чулууны холимог материал ашиглах нь зөв аж.

Усны шинэ эх үүсвэр гэдэг утгаар төслийн ТЭЗҮ-ийг Усны нөөцийн зөвлөлөөр хэлэлцүүлэх шаардлагатай. Тиймээс УСУГ-аас ойрын хугацаанд яаманд хүсэлт гаргаж хэлэлцүүлэхээр ажиллаж байгаа гэсэн. Туул усан цогцолбор нь дан ганц усан сан барих асуудал биш. Үүний дэргэд 250 мянган шоо метрийн хүчин чадалтай цэвэршүүлэх байгууламж, усан цахилгаан станц, ус хангамжийн зэрэг хэд хэдэн байгууламж давхар сүндэрлэх нь.

ТЭЗҮ-ээр эхний ээлжинд 30 жил дуншсан усан боомтыг барих байршил, шаардлагатай хөрөнгийн хэмжээ тодорхой болно. Ингэснээр Монголын тал хөрөнгө оруулагчдад “Туул усан цогцолбор” барих бэлэн төслөө үзүүлэх боломжтой болно гэсэн үг. Улаанбаатар хотын цэвэр усны өнөөгийн тэжээгч байгаль бол цаашид байгаль, технологийн хослол байх нь. Энэ нь ч оновчтой шийдэл, олон жилийн хүсэл мөрөөдөл биелэх эхлэл тавигдаж байна хэмээн салбарынхан онцлон, олзуурхаж байна. ■

Төв цэвэрлэх байгууламж

АСЕМ биднийг хүлээхгүй



Зургийг Б.Сэр-Од

Ц.БАДРАЛ

Төв цэвэрлэх байгууламжийн асуудлыг ирэх долдугаар сараас өмнө амжиж шийдвэрлэхийг хотын удирдлагуудад Засгийн газраас үүрэгдсэн. Үнэн хэрэгтэй жинхэнэ даалгавар өгөгч нь АСЕМ юм.

Хэргийн эзэн болсон хур лаг 15 га газрыг хамарч байгалийн жамаар өөрөө хагаж байгаа юм. Ингэж байгальд хагаах процесс удаан үргэлжилдэг. Дор хаяж гурван жил болдог байна. Дээрээс нь өдөр бүр 500-600 шоо метр лаг шинээр гарч буй.

Өнгөрсөн жилээс цэвэрлэх байгууламжийн таагүй үнэр урьд жилүүдээс илүүтэй хамар цоргих болсон шалтгааныг УСУГ-аас шалгаж биологийн цэвэрлэгээ хийгдэхгүй байсныг нь тогтоожээ. Биологийн цэвэрлэгээ нь зориулалтын шүүлтүүрт тогтох боломжгүй усанд ууссан

хорыг бичил биетүүдээр идүүлж өөр төрлийн лаг болгож хувиргадаг байна. Улаанбаатар хотын газар доогуур бохир татан зайлуулах хоёр том коллектор (шугам хоолой) явдаг. Нэг нь үйлдвэрлэлийн районы бохирдлыг татан төвлөрүүлж урьдчилан цэвэрлэх байгууламжид аваачдаг. Энд химийн цэвэрлэгээ хийгдсэний дараа Төв цэвэрлэх байгууламжид нийлүүлдэг. Нөгөө нь айл гэр, албан байгууллагаас гарч буй ахуйн чанартай бохирдлыг татан төвлөрүүлдэг төв коллектор. Гэтэл хоёр коллектоороор урсаж буй бохирт дүн шинжилгээ хийж үзэхэд төв коллекторынх нь илүү бохирдолтой болох нь тогтоогджээ. Энэ нь нийслэлд олон тооны машин угаалгын газар, махны үйлдвэр, ресторан үйлчилгээний газрууд ажиллаж маш их хэмжээний угаалгын химийн бодис ▶

► ашигладгаас үүдэлтэй аж. Түүнээс гадна өрхийн хэрэглээнд ч химийн найрлагатай олон төрлийн цэвэрлэгээний бодисууд нэвтэрсэн. Ингээд төв коллектороор нийлүүлэгдсэн хор ихтэй бохир Төв цэвэрлэхийн бичил биетүүдийн ажлыг хийлгэлгүй үхүүлчихээд байж.

Үлдэж буй хугацаанд

Одоо АСЕМ-тай уралдаж төв цэвэрлэхээс гарч буй үнэрийг дарах том ажил иргэдийн анхаарлын төвд байна. Үнэрээ дарж амжих болов уу? Лаг хагах явцыг хурдасгаж, чийгийг богино хугацаанд салгадаг үндэсний үйлдвэрүүдийн “Арвай-3”, “М” зэрэг технологи ч байдаг аж. Гэхдээ дотоодын үйлдвэрүүдийн санал болгож буй технологи нь нэгэнт үйлдвэрээс ялгарсан лагийн үнэрийг дарах төдий цэвэрлэгээний бодисууд учраас гаднын технологи авах бололтой. Жинхэнэ бай бол үнэр бус түүнийг буй болгож байгаа цаад шалтгаан юм. Үүнийг учир илүүтэй техникийн шийдэл хэрэгтэй. Сүүлийн үеийн олон улсад ашиглаж байгаа центрфунк төрлийн технологи нь маш богино хугацаанд лагийг уснаас нь салгадаг байна. Чийг ихтэй байх тусмаа үнэр их байдаг хэмээн Нийслэлийн Засаг даргын орлогч Т.Бат-Эрдэнэ онцлов.

Ийм төрлийн технологи нь заавал тухайн орчин нөхцөлд нь тохируулж хэмжээ загвар бүтээж, араа соёо бүрийг шинээр хийх хэрэгтэй болдог гэнэ. Үүнд ойролцоогоор 40-45 хоног зарцуулдаг аж. Дараагаар нь авчирч угсарч, туршина. Түүнээс урьтаж барилгын засварын ажлыг дуусгах, цахилгаан хангамжийг сайжруулах гээд ажил их. Үүнд үлдэж байгаа гурван сар тийм ч хангалттай биш.

Хотын захиргаа ажлыг зургадугаар сарын 15-наас өмнө дуусгахаар төлөвлөжээ. Гэхдээ олон нийтийг бухимдуулсан үнэрийг бүрэн арилгаж чадахгүй нь. 70-80 хувиар бууруулах боломжтой аж. Үүнд цаг хугацаа, хөрөнгө мөнгө нөлөөлж байна. Эвгүй үнэрээс бүр мөсөн салъя гэвэл Төв цэвэрлэх байгууламжийг бүрэн шинэчлэхээс өөр арга зам байхгүй.

Алдсан цагийн бүтээмж

Засгийн газар төв цэвэрлэх байгууламжийн үнэрийг дарахад зориулж 8.1 тэрбум төгрөгийг нэгдүгээр сарын 6-нд Нийслэлийн дансанд шилжүүлжээ. Энэ мөнгөөр оновчтой ямар ажил хийх саналаа Засгийн газарт танилцуулах үүргийг Нийслэл хүлээж байв. Үүний дагуу

Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т.Бат-Эрдэнээр ахлуулсан ажлын хэсэг байгуулагдаж олон компанийн саналд үндэслэн өөрсдийн зөвлөмжийг боловсруулжээ. Гэтэл өнгөрсөн хоёрдугаар сарын 22-нд Нийслэлийн Засаг дарга “эрх шилжүүлэх тухай” захирамж гаргаж Улаанбаатар хотын ерөнхий менежер, Захирагчийн ажлын албаны дарга Б.Бадралд уг ажлыг шилжүүлэв. Ингээд дахин ажлын хэсэг байгуулагдаж сар шахам хугацаанд ажилласны эцэст цоо шинэ технологи нэвтрүүлэх цоо шинэ санал боловсруулж хэдхэн хоногийн өмнө Засгийн газарт танилцуулаад байна.

Яараад байгаа боловч одоогийн байдлаар ханцуй шамлан ажилдаа орчихоогүй л байна. Ялангуяа гүйцэтгэгч сонгон шалгаруулах тал дээр нэлээд хаширлаж байгаа бололтой. Асуудалд бодитой хандаж, тооцоо судалгаагүй хэн бага үнэ хэлсэн, богино хугацаа амласан “Би чадна” сонгочихвол нөхөх аргагүй цаг хугацаа, хайран хөрөнгө мөнгө болно. “Хүн бүхэн болно чадна гэсэн технологио үзүүлж л байна. Гол нь хуримтлагдсан лагт тохирох нь мөн үү гэдгийг лавлаж үзэх хэрэгтэй. Эс бөгөөс үр дагавар нь улам л хүнд байх болно” гэж Бат-Эрдэнэ хэлсэн. Манай Төв цэвэрлэх байгууламжийн лаг нь гадаадын хотуудынхтай харьцуулахад маш их өөх тос агуулсан учир санал өгсөн компаниуд дотор шулуухан чадахгүй гэж хэлсэн нь ч бий гэнэ. Одоогоор 10 гаруй компанийн технологийг туршиж үзжээ. Буруу компани сонгочих вий, “ТЭЦ-2”-ын коксжсон түлшний үйлдвэр шиг бүтэлгүйтэх вий гэсэн айдас байгааг ч нуусангүй. Гэхдээ цаг хугацаа явсаар л. АСЕМ болох үеэр үнэр арилах уу үгүй юу гэдэгт өгөх хариулт улам бүрхэг болсоор.

Алсыг харвал

Үнэр дарах асуудлыг сонгууль, АСЕМ-ийн хурал гэсэн цаг үеийн үйл явдалтай холбох нь утгагүй, харин түүнээс чухал асуудал болох иргэдийн эрүүл мэндтэй холбон ярих ёстой гэж УСУГ-ын дарга С.Үнэн үзэж буй. Үнэхээр ч цэвэрлэх байгууламжийн асуудал аль ч цагт хурцадмал сэдэв байж ирсэн.

Тэрбээр “Нийслэлчүүд энэ үнэрээр амьсгалж байгаа. Хамгийн гол нь үнэр гаргахад хүргэж буй үндсэн шалтгааныг нь шийдэх нь зүйтэй” гэв. УСУГ-ын дарга ирээдүйгээ бодвол усыг бохирдуулагч субъектууд дээр илүү анхаарал хандуулах хэрэгтэй гэдэг талаас нь хандаж байгаа юм.

Уг нь холбогдох яам, тамгын газраас аж ахуйн нэгжүүдэд үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгохдоо үйлдвэрийн хог хаягдал, бохирдолд тавигдах стандарт шаардлагыг тавих учиртай. Гэтэл тусгай зөвшөөрөл олгогчид тэр тухай ор тас умартсанаас бохирын шугамд нийлүүлэгдэж буй бохир ус байх ёстой хэмжээнээсээ 60 дахин бохирдолттой байдаг гээд бод доо. Энэхүү нийслэлчүүд бидний дэндүү их бохир ус үйлдвэрлэж байгааг илтгэх тоо нь УСУГ-ын шалтгалтаар тогтоогдсон байна. Ус суваг мэргэжлийн байгууллагын хувьд үүнд санаа тавьдаг болохоос биш, хаана хэн их бохир үйлдвэрлэж байна гээд зөрчлийг илрүүлж, хариуцлагын арга хэмжээ авах эрх тэдэнд байдаггүй аж. Тиймээс хог үмхийрэх нэг үндэс нь энэ байжээ. Уг нь УСУГ-ын удирдлагад улсын байцаагчийн эрх олгочиход л асуудлыг шийдчих боломж харагдана. Яагаад гэвэл Улаанбаатарын усан хангамж, шугам хоолойгоор гүйж байгаа цэвэр, бохир усны асуудал тус газарт хамааралтай учраас. Гэтэл манай сайд, дарга нар ногоон хөгжил, ногоон эдийн засаг гэж энд тэндгүй их ярьдаг хэрнээ өнөөдрийг хүртэл ус бохирдуулагчид тавих хяналтаа умартсан нь тун хачирхалтай.

Цаашлаад муухай үнэр гаргаж, муу хэлүүлэх дээрээ тулсан Төв цэвэрлэх байгууламжийн хүчин чадлын асуудал. Усны бохирдол их байгаагийн дээр угаас хотын дэд бүтэц тэлэхийн хэрээр байгууламжийн хүчин чадал мөхөсгөж буй.

Төв цэвэрлэх байгууламж 1964 онд ашиглалтад орсноосоо хойш хагас зууныг элээжээ. 1979, 1986 онд өргөтгөл шинэчлэл, хийсэн бөгөөд зарим тоног төхөөрөмжийн хувьд анх суурилуулсан хэвээрээ. Тус байгууламж хоногт 170 мянган шоо.метр ус хүлээн авч, цэвэрлэх хүчин чадалтай атал өнөөдөр 190 мянган шоо.метр хүрчээ.

Уг нь хоногт 250 мянган шоо.метр ус цэвэршүүлэх чадалтай цэвэрлэх байгууламж шинээр барихаар УИХ 2013 онд шийдвэрлэсэн ч ярианаас цаашгүй өнөөдрийг хүрэв. Энэ тухай “Шинэ байгууламж барихдаа аль болох хурдан гүйцэтгэх шаардлага бий. Үүний зэрэгцээ одоо байгаа ганцгаа ч давхар шинэчлэн сайжруулах болно” гэж Т.Бат-Эрдэнэ хэлсэн.

Гэхдээ хэрхэн шийдэх нь бүрхэг байгаа нэг асуудал нь санхүүжилт. Төлөвлөгөө ёсоор 2020 онд ашиглалтад орох учиртай шинэ цэвэрлэх байгууламжийг барьж ашиглалтад оруулахад ойролцоогоор 320 сая ам.доллар шаардлагатай гэсэн ТЭЗҮ гарсан юм. ■

ХУВИЙН ТЭТГЭВРИЙН САН ГЭЖ ЮУ ВЭ?



Ажилтны нэр дээрх дансанд байгууллага тухайн ажилтантай хамтран урамшууллын систем хэлбэрээр хуримтлал үүсгэнэ.

Тэтгэврийн сан уг дансан дахь мөнгөн хөрөнгийг удирдаж, эргэлтэнд оруулснаар ажилтны хуримтлалыг үнэ цэнийн бууралтаас хамгаалж, өсгөхийн зэрэгцээ хуримтлагдсан эх үүсвэрийг эргэлтэнд оруулснаар эдийн засгийн хөгжилд томоохон дэмжлэг үзүүлдэг.

Усны хомсдол XXI зууны хамгийн хурц асуудал болох нь

НҮБ-ын таамаглаж буйгаар 2025 он гэхэд дэлхийн нийт хүн амын гуравны хоёр нь усны хомсдолд орох судалгаа бий

Ус хүн төрөлхтний амьдралын эх булаг бөгөөд хүний биеийн 70 хувь нь уснаас бүтдэг



2
минут

цоргоныхоо усыг гоожуулж шүдээ угаавал жилд 7000 л ус ашиггүй зарцуулна.

1

цаг дусахад

0,54
литр

1

хоног дусахад

13
литр

7

хоног дусахад

90
литр

1

жил дусахад

33112
литр

ЦЭВЭР УСНЫ ХОМСДОЛ

Дэлхийн хүн амын

20

орчим хувь буюу ойролцоогоор

1.1

тэрбум хүн цэвэр усны хомсдолд ороод байна. Барагцаалбал өдөрт

4500

хүүхэд цэвэр, аюулгүй ус хэрэглэж чадахгүй байгаагаас нас барж байна.

Дэлхийн нийт хүн амын

85%

нь хамгийн хуурай цөлжилттэй бүсэд амьдарч байна.

Дэлхийн бүх усны **2.5** хувь нь цэвэр ус

Дэлхийн нийт усны **30** хувийг нь хэрэглэх боломжтой

Дэлхийн хөгжиж буй улсууд дахь өвчний

80 хувь нь устай холбоотой байдаг

Хөгжиж буй улсуудын усны хэрэглээний

50 хувь нь шугам хоолойн ус алдалтаас болж үгүй болдог

Дэлхийн хүн амын дөрөвний нэг нь ус хэрэглэх бололцоогүй байдаг

20

секунд тутамд нэг хүүхэд ариун цэвэр хангалтгүйн улмаас нас бардаг

Найробигийн хотын оршин суугчид Нью-Йоркийн оршин суугчдаас 10 дахин илүү үнэ усанд төлдөг

“Усчдын” эрэлд

Б.ЭНХЦЭЦЭГ

Өдгөө дэлхий даяар 1.5 тэрбум хүн устай холбоотой салбаруудад ажилладаг. Өргөн хүрээнд харвал, бараг бүх ажлын байр ус ба түүнийг аюулгүй хүргэх үүргийг хүлээдэг хүмүүсээс шалтгаалдаг. Дэлхийн долоон тэрбум гаруй хүнийг ундаалах ажилд одоо байгаагаас илүү олон хүн шаардагдах нь.

НҮБ өнгөрсөн жил Дэлхийн усны өдрөөр тухайн жилийн чиг үүргээ “Ус ба Тогтвортой хөгжил” гэж тодорхойлж байсан бол энэ жилийнх “ Ус ба Ажил”. Өөрөөр хэлбэл, усны хэмжээ ба чанарын хүртээмжтэй байдал нь хөдөлмөр эрхлэгчдийн амьдрал, ахуйг хэрхэн өөрчилж цаашлаад нийгэм, эдийн засгийг яаж өөрчлөн байгуулах чадалтай вэ гэдэг нь дээрх урианы цаад санаа.

Дэлхий нийтийг нэгдэхэд хүргэж буй түгээмэл асуудал болох уур амьсгалын өөрчлөлт, хүн амын өндөр өсөлт мөн хотжилтийн сөрөг нөлөөлөл нь утгаа усны эх сурвалжууд дээр хамгийн хүндээр тусаж буй. Тиймээс энэ нь байгаль орчны чиглэлээр тэр дундаа усны чиглэлээр ажлын байрны эрэлтийг нэмэгдүүлэх хандлагатай байгааг олон улсын шинжээчид онцолж байна. Энэ дундаас гурван төрлийн салбар /Засгийн газар, Зөвлөх үйлчилгээний компаниуд, усны байгууламжууд/ усны чанарыг хангаж ажиллах мэргэжилтнүүдээр ангаж цангах төлөв бий. Энэ хандлагыг дагаад мэргэжлийн боловсон хүчинг зах зээл хүсэмжлэх болжээ. Өдгөө зөвхөн усны чанар шалгагчийн ажлаар жишээлэхэд, ажил олгогчдын 75 хувь нь бакалаврын зэрэг шаарддаг ч бодит байдалд нийт салбар даяар ажиллаж буй хүмүүсийн ердөө 25 хувь мэргэжлийн зэрэгтэй байдаг байна.

Манай улсын усны салбарт 10.000 хүн ажиллаж байгаа гэх тоо байна. Үүнээс тусгай зөвшөөрөл эзэмшиж буй мэргэжлийн байгууллагуудад 5000 орчим хүн ажиллаж байна. Тэдний хэд нь усны чиглэлээр мэргэшсэн



НЭГ ТЭРБУМ

хүн газар тариалан загасчлал, мод үржүүлгийн салбарт ажилладаг. Усны чанар, хэмжээний хувьд хүртээмжтэй байдал нь энэ төрлийн салбарын хөдөлмөр эрхлэгчдэд гол амин зуулга.



ДОЛООН ТЭРБУМААС ИЛҮҮ ОЛОН ХҮНИЙГ ТЭЖЭЭЖ

УНДААЛНА гэдэг амар даалгавар биш. Тэр тусмаа үүр амьсгалын өөрчлөлттэй нүүр тулсан энэ үед, усанд гамтай ханддаг газар тариалан эрхлэгчдийн үүрэг хариуцлага тэр чинээгээр нэмэгдэж буй.



боловсон хүчин бэ гээд харахаар цөөн. Манайх 1960 оноос хойш устай холбоотой мэргэжлээр төр засгийн төлөвлөгөөтэйгээр боловсон хүчин бэлтгэж, төгсөлт хийж, төгссөндөө ажлын байр оноон эрэлт нийлүүлэлтийг тэнцүүлдэг байсан. Харин өдгөө дээрх боловсон хүчин, ажлын байрны хуваарилалт алдагдаж зах зээлийн зарчмаар явж буй. Мэргэжлийн салбараар нь аваад үзвэл 20 орчим төрлийн үндсэн мэргэжлээр төрийн болоод хувийн хэвшлийн их дээд сургуулиуд элсэлт авч сургаж буй. Томоохон сургуулиудаар багцаалан тооцбол, жилдээ 70 шахам оюутан мэргэжлийн зэрэгтэй болж төгсөж байгаа аж. Тэдний дийлэнх нь хувийн хэвшлийн компаниудад шингэдэг. Бас цөөнгүй нь өөр салбар руу хөрвөдөг. Эдгээр бэлтгэгдсэн боловсон хүчний хувьд геологи хайгуул, геофизикийн судалгааны компани, ус хангамжийн компани, өрөмдлөгийн компани, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэн, байгаль орчин болон инженерингийн консалтинг компани, засгийн газар, уул уурхай, эрчим хүч, хими, төмөрлөг, эм, хог хаягдал боловсруулах үйлдвэр, их сургууль,

олон улсын төсөл, хөтөлбөр гээд олон талбарт ажиллах боломж уг нь бий.

Усны салбарт эмэгтэйчүүд гол төлөв зураг төслийн компанид, эрэгтэйчүүд угсралт, сантехникийн компанид орох нь элбэг. Өнгөрсөн хавар Ус хангамж, цэвэрлэгээний чиглэлээр их сургуулиа төгссөн О.Бямбадэлгэр төгссөнөөсөө хойш удалгүй ажилд орсон бөгөөд тус мэргэжлийг зах зээлд эрэлт ихтэй, нарийн мэргэжил гэдэг утгаар нь анх сонгожээ. Түүний хэлж байгаагаар бол ажил олоход тийм хэцүү байгаагүй аж. Харин Бямбадэлгэртэй хамт төгссөн Э.Пүрэвдуламын хувьд одоо болтол ажилд орж чадаагүй. “Учир нь хувийн компаниудад ажилд орохоор очиход биеэ даагаад ажиллах олон жилийн туршлагатай хүн авахыг илүүд үздэг учир сургаад авах сонирхолгүй байдаг” гэлээ. Тэрбээр энэ чигээрээ ажилд орж чадахгүй удвал өөр салбарт ажиллахаас өөр аргагүйд хүрнэ гэсэн юм. Төсөл хөтөлбөрөөр амь зогоодог зарим хувийн хэвшлийнхний хувьд эдийн засаг удааширсан энэ үед хийх ажил бага байгаа учир ажилтнуудаа өвөл амраах, шинэ ажилтан авахгүй байх зэрэг хэмнэлтийн арга хэмжээ авч байгаагай ▶



НЭГ ЦАГТ 38

ажилтан устай холбоотой өвчнөөр нас бардаг. Усны чанар, эрүүл ахуйг сайжруулснаар эдгээр өвчлөлөөс сэргийлж болно.



УСНЫ 2030 ОН ХҮРТЭЛХ ХӨТӨЛБӨРИЙН ДАГУУ

усны салбарын хэрэгцээ үлэмж хэмжээнд нэмэгдэнэ. Тиймээс тогтвортой хөгжил бүхий ирээдүйг бүтээхэд энэ салбарт илүү олон мэргэжлийн боловсон хүчин шаардлагатай.



УС ЗӨӨХ НЬ

ихэнхдээ ажилд үл тооцогдож, дорвитой цалин хөлс авдаггүй. Ажлыг зохих ёсоор нь үнэлэх нь ялангуяа эмэгтэйчүүдийг чадавхжуулах том алхам юм.



► үүнийг холбон тайлбарлах хэсэг байна.

Сургуулийн ширээнээс ховхорсон “усчин” залуус 9-10 мэргэжлийн хүрээнд дийлэнх нь ажилд орцгоодог байна. Түгээмэл мэргэжил биш учир ажлын байрны олдоцын хувьд бусад салбартай харьцуулахад боломжийн сайн гэсэн үнэлгээг салбарын мэргэжилтнүүд өгч байна. “Усны чиглэлээр мэргэжил эзэмшсэн залуусын ажлын байрны олдоцын хувьд арай ч дэлгүүрийн лангууны ард зогсоход хүргэхээр тийм хомс биш. Ажлын байр бий” хэмээн Хүрээлэн буй орчны инженерийн салбарын профессор С.Чулуунхуяг хэлсэн юм. Гэхдээ эрэлт нийлүүлэлтийг учруулах тал дээр ойд төөрчихсөн мэт учир замбараагүй байгаа нь үнэн хэмээн тэрбээр мөн хэлсэн юм.

Устай холбоотой мэргэжлүүд нь манай улсын хувьд нэн хэрэгцээт нарийн мэргэжлүүдийн тоонд ордог. Бусад салбартай харьцуулахад цалингийн дундаж нь өндөр буюу 480 мянган төгрөг. Энэ төрлийн мэргэжлээр ойрын жилүүдэд ажилд орсон туршлага багатай залуусын эхлэл цалин нь 600-700 мянган төгрөгийн хооронд хэлбэлзэж байна. Харин гаднын улсад энэ

төрлийн мэргэжилтнүүдийн цалингийн хэмжээ манай улсын жишгээс хэд дахин дээгүүр. Тэтгэвэрт гарсан ч мэргэжлээрээ зөвлөх хийх боломж өндөр байдаг. “Бидний тооцоогоор устай холбоотой томоохон баримт бичгүүдийг хэрэгжүүлэхэд 1500-2000 орчим мэргэжлийн боловсон хүчин хэрэгтэй болно” хэмээн БОНХАЖЯ-ны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга Г.Мөнх-Эрдэм хэлсэн юм. Түүний хэлж байгаагаар дээрх мэргэжилтнүүдийн хэрэгцээг гаднын улсуудаас бүрдүүлнэ гэдэг хэтэрхий өндөр зардалтай гэсэн. Тиймээс дотоод бололцоогоо ашиглах шаардлага гарах аж. Бидний хувьд залуусаа гаднын өндөр хөгжилтэй орнуудад сургаж ажиллуулах нь “Know-How” буюу юуг хэрхэн хийх вэ гэдэг асуултад хариулт авах дөт зам байж болох.

Өдгөө дэлхий даяар хүрээлэн буй орчин, байгаль орчны чиглэлээр төрөл бүрийн хөтөлбөр, тэтгэлэг зарлаж, залуу үеийг энэ чиглэлд сурахыг хөхиүлж буй. Энэ сонирхол манайд ч бий. Олон улсын засгийн газрууд өөрсдийн нэрэмжит тэтгэлэг зарлахдаа байгаль

орчны чиглэлээр сурахыг эрмэлзсэн хүмүүсийг түлхүү дэмжиж тэдэнд илүү боломж олгохыг хичээдэг. Гэхдээ тэд тогтоосон шалгууруудаа мэдээж харгалзана. Профессор С.Чулуунхуягийн хэлж байгаагаар бол багш нар болон сургуулиудын зүгээс оюутнуудаа олон улсад сургах сонирхол өндөр, хичээл зүтгэл гаргадаг ч гадаад хэлний мэдлэг тааруугаас үүдэн гологдох нь олон гэнэ. Тэтгэлэгт хөтөлбөрүүдийн хувьд хангалттай боломж бий. Гол нь залуус өөрсдөө хичээх хэрэгтэй байгааг тэрбээр мөн санууллаа.


Усны салбарынхан гээд л зөвхөн нэг салбарынхны эрх ашгийн тухай яриад байгаа мэт боловч угтаа энэ нь гурван сая монгол хүний, дэлхийн долоон тэрбум хүний уух усны тухай асуудал. Шууд оролцдоггүй ч шууд бусаар хүн бүхэн устай холбоотой үйл ажиллагаанд оролцож байдаг. Тогтвортой хөгжилд хөтөлгөдсөн ирээдүйг бүтээхэд байгаль орчны салбарт илүү олон мэргэжлийн боловсон хүчин олон улсад хэрэгтэй болох нь тодорхой гэж НҮБ үзэж байна. Харин бид энэ хандлагаас хаа холдох вэ. Ус хүний анхдагч хэрэгцээ биш гэж үү. ■

Ус бол ажил



Ясмина, Франц

Мянга, мянган хүүхэд усгүйгээс үүдэн нэг өдөрт нас бардаг гэж сонссон. Хүүхэд асрагчийн хувьд усны чанар хэмжээ нялх хүүхдийг асрахад асар чухал. Усны дусал бүрийг хэрхэн зарцуулдагаа бодоод үзэхээр төсөөлөхөд ч бэрх мэдрэмж төрдөг.




Жулиэн Мони, Загасчин

Загасчлах бол миний амьдралаа залгуулдаг ажил. Усгүй бол загасгүй. Ийм учраас ус ба чийглэг газрыг сайн харж, хамгаалах нь чухал юм. Би загасчлалын гар хэрэгслүүдийг ашигладаг. Энэ нь өөрт хэрэгтэй хэмжээний загасаа барихад тусалдаг. Ийм байдлаар би өөрийгөө гол, нуур, загасанд хүндэтгэл үзүүлж байна гэж итгэдэг. Швейцарьт загасчлалыг хэзээ, хэрхэн гэхчлэн нарийн зохицуулдаг. Энэ бол тэд бидний ирээдүйд санаа зовж буйн илрэл.



Гай Райдар, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Ерөнхий захирал, НҮБ-Усны байгууллагын дарга

Ус бидний ажиллах орчин нөхцөлд амин чухал. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын хувьд агааржуулагч ажиллуулахдаа Женевийн нуурын усыг ашигладаг. Ус бол ажил.



Шилпа Дахакэ, Судлаач

Урсан өнгөрч буй өдөр бүр усны үнэ цэнийг нэмэгдүүлж байна. Гол горхиуд нь усны чухал эх сурвалж ч хүний үйлдлүүд экологи, гидрологи болон голын урсацад сөргөөр нөлөөлж буй. Миний судалгаа нь нийгэм-соёлын хэмжээс, хотжилт болон голын экологи гэх асуудлуудыг нэг дор авчрахыг оролдож буй. Энэ замаар голуудтой холбоотой асуудлуудыг шийдэхэд хүмүүсийг чадавхжуулж, ойлголтыг нэмэгдүүлнэ гэж найдаж байна.



Кажса, Норвеги

Зоогийн газар ажиллуулдагийн хувьд чанар сайтай, хүрэлцээтэй устай байх нь амьдрал, ажлын минь зайлшгүй нэг хэсэг. Бидний ихэнх нь гал тогоо, угаалгын өрөөны угаалтуураасаа усаа авчирдаг. Тиймээс үндсэн хэрэгцээ болох усыг зарим газар хүмүүс, хүүхдүүд өдөрт зургаан цаг алхаж очиж авдаг гэхээр галзуурмаар. Та өөрийгөө ингэж амьдарч байна гэж төсөөлж чадах уу?



Лиза ба Эмма

“Make It Last” брэнд утас хийх, даавууг өнгөнд оруулах, хувцас угаах зэргээр их ус хэрэглэдэг загварын ертөнцөд бид ажилладаг. Бүгд далайн загас, хөрсөн дэх үр тариа, шударга нөхцөлд ажилладаг хүмүүст дуртай учир бидний хувьд тогтвортой шийдлүүдийг сонгох нь мэдээжийн зүйл байх ёстой.



Брайтон, Малави

Ус надад ажил бэлэглэсэн. Би өөрийн гэсэн бизнесээ эхлүүлсэн бөгөөд өдгөө би хүмүүсийг эрүүл ахуйн шаардлага хангасан чанартай усаар хангадаг.

Яагаад Дэлхийн усны өдөр гэж?

Дэлхийн усны өдөр нь олон улсын хувьд усны тухай асуудлуудыг олны анхааралд аваачих, бусадтай энэ асуудлын талаар хэлэлцэж, өөрчлөлтийн төлөө алхам хийх боломжийг олгодог. Анх 1992 онд НҮБ-ын чуулганаар усны асуудалд илүү их анхаарал, зүтгэл хэрэгтэй гэх санал гарсан. Ингээд НҮБ-ын Ерөнхий Ассемблей Дэлхийн анхны усны өдрийг 1993 оны гуравдугаар сарын 22-ноор эхлүүлэх шийдвэрийг гаргасан юм. Үүнээс хойш жил бүр НҮБ-ын Ус хариуцсан байгууллага нь ус ба эрүүл ахуйтай холбоотой ажлыг зохион байгуулж өдийг хүрсэн. Жил бүр усны өдрийг тодорхой сэдвээр “малгайлдаг” бөгөөд энэ нь тухайн жилийн ажил үүргийн чиг болдог. ■



Ранажит Кумар Мондал

Би устай холбоотой ажил хийж амьдралаа залгуулдаг. Бангладешийн баруун өмнөд бүс үндны усны төлөө үхэхээс буцахгүй болсон. Усны хямралд орсон энэ үед эмзэг бүлгийн хүмүүсийг дэмжин ажиллаж байгаадаа жаргалтай байдаг. ▶



Жойз Антонио Руйз, Испани

Бид Испанид бохир усыг цэвэршүүлдэг. Дэлхийн усны эргэлтэд чанартай ус нийлүүлж чадаж байгаа нь эерэг, тогтвортой үйл ажиллагаа.



Нераж Капүүр

Би хэдийгээр Мэдээлэл технологийн мэргэжилтэн ч ус хэмнэх шийдлүүдэд бодлоо чиглүүлж, загварчилдаг маань надад баяр баясал авчирдаг. Энэ миний ажил тэгээд нийгмийн өмнө хүлээсэн үүрэг.



Аржен Хоекстра, Профессор

Би судалгааны багтайгаа хамтран дэлхий хэрхэн тогтвортой, хэмнэлттэй, тэгш хуваарилалт бүхий усны хэрэглээтэй ирээдүй рүү урагшилж болохыг ойлгохыг зорьж буй. Саяхан бид дэлхий даяар голын сав газруудаар усны хэрэгцээт дээд хэмжээг үнэлж тогтоосон. Ингэснээр засгийн газрууд усны хэт түгээлтээс зайлсхийж чадна. Бид мөн бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэхэд зориулсан усны жишиг хэмжээг гаргах гэж байна. Энэ нь компаниуд хэрхэн боломжит түвшинд усны хэрэглээгээ барихаа мэдэхэд тусална.



Агнес Бэрегсзази, Будапешт

Би рашаан сувиллын хот гэгддэг Будапештэд амьдардаг. Усан эмчилгээний эмчээр ажиллаж байгаа нь намайг энд халуун рашаан устай холбож байдаг. Би усны эдгээх хүчийг үргэлж харж биширдэг учир усыг эрдэнэ гэж үздэг. Будапештийн халуун рашаан ус нь энэ хотын өвөрмөц чанар. Тиймээс Засгийн газар үүнийг сайн харж хандан, ирэх он жилүүдэд илүү олон хүнд хүртээмжтэй байлгана гэж найдаж байна.



Моа, Швед

Би залуус, ижил тэгш байдлын асуудал хариуцан голдуу оффист сууж ажилладаг. Толгойг минь сэргэг байлгадаг кофенд би их дуртай. Гэхдээ ганцхан аяга кофе хийхэд 140 литр ус хэрэглэдгийг би сайн мэднэ. Өдрийн ажилдаа төвлөрч, ажлаа сайн хийж, аз жаргалтай байлгадаг ус чамд баярлалаа.



Эрик Шёрч, Сан Диего

Дэлхийг өөрчлөгч. Энэ бол өнгөрсөн найман жилд АНУ-ын Хил хязгааргүй инженерүүд хэмээх байгууллагад хийж ирсэн бусдын амьдралыг өөрчилдөг ажлыг минь тайлбарлах төгс тодорхойлолт.

Энэ байгууллага усны хангамжийг сайжруулах ажил хийх замаар олон хүний амьдралыг өөрчилж буйг харсан. Мөн энэ байгууллагад сайн дураараа ажилладаг хүмүүсийн амьдрал ч өөрчлөгддөг нь гайхалтай.



Сьюзан Чидэбэ

Өнгөрсөн жил тосгонд шинэ худаг гаргахаас өмнө бид усаа авах гэж өдөр бүр гурван км гаруй алхах хэрэгтэй байв. Хүүхдүүд ингэж хол алхдагаас үүдэн сургуульдаа явахаас өмнө өглөө маш эрт босох хэрэгтэй болдог. Харин одоо тэд хичээлдээ илүү шамдаж, цагаасаа хоцрохгүй байгаа. ■



Сунанка, Нигерь

Хэрвээ би хүсвэл зарж буй бүтээгдэхүүнээ илүү үнэтэй борлуулж чадна гэдгээ мэднэ. Гэхдээ хүн бүр миний зарж буй усны данхыг / гар угаах зориулалттай/ авч дийлэх чадвартай байх нь чухал. Бид энэ нийгмийг илүү цэвэр, эрүүл газар байлгахыг хичээж байна.



М С М Х С V

ХӨГЖЛИЙН ГОЛОМТ

Бид нийгмийн хөгжлийн
тулгуур нь байж сайн сайхныг
түгээж ажилладаг

 **ГОЛОМТ БАНК**
Сайн сайхныг санхүүжүүлнэ

 www.golomtbank.com



Менежмент

Цэнхрээс ногоон

Орчуулсан Б.ТУЯА

“Дэлхийн эрсдэлийн тайлан-2016”-д хүн төрөлхтний туулж буй хамгийн том гурван гачлангийн нэг нь усны хямрал гэжээ. Энэ дүгнэлтийг батлах саяхан гарсан нэгэн судалгаанд дэлхийн нийт хүн амын 2/3 буюу дөрвөн тэрбум хүн усны хомсдолтой нөхцөлд амьдарч байгааг дурьдсан байна.

Дөрвөн тэрбум гэдэг бидний төсөөлж байснаас ч их тоо. Өнгөрсөн хугацаанд усны хомсдолыг судлахдаа жилийн дунджаар тооцдог, улмаар 1.7-3.1 тэрбум хүн усны ямар нэг асуудалтай бүсэд аж төрж буй гэдэг байлаа. Энэ удаа усны асуудлыг илүү нарийвчлан судалсан бөгөөд жилээр биш сарын дундаж үзүүлэлтэд суурилан цэвэр усны хомсдол гамшгийн хэмжээнд хүрсэнийг нотолжээ. Түүнчлэн усны хомсдолд өртөж буй хүмүүсийн тал хувь нь Хятад, Энэтхэгт амьдардаг, хагас тэрбум хүн усгүй шахам амьдарч байна гэжээ. Мөн АНУ, Австрали, Европ болон Ойрхи Дорнодын газар нутгуудыг хэсэгчлэн судалсан байна.

Сүүлийн үеийн тооноос харахад 500

сая хүний усны хэрэглээ зарим бүсэд жилийн туршид орох хур тунадасны хэмжээнээс хоёр дахин давсан байгаа юм. Хур тунадасны хэмжээ ийн буурч буй нь гүний уст давхарга хатаж, улмаар амьд биесийн амьдрах нөхцлийг улам хүнд болгож байна. Тэгэхээр бид юу хийх ёстой вэ?

Судалгаанд зөвлөж буйгаар бид өдөр тутмын усны хэрэглээгээ илүү хүртээмжтэй болгож, хандлагаа өөрчлөх хэрэгтэй аж. Гэвч энэ тийм ч амар байхгүй. Эрдэмтэд “XXI зуун хүн төрөлхтний хувьд хүнд сорилтуудтай нүүр тулах зуун” гэж тодорхойлж байгаа. Калифорни мужид ган тохиох нь элбэг. Тус мужийн усны хэрэгцээг Сиерра Невадагийн цас хангадаг бол өнгөрсөн онд цаст уулаас буух усны хэмжээ 500 жилийн хамгийн доод түвшинд хүрчээ. Улмаар 39 сая оршин суугч үүний үр дагаварыг тодорхой хэмжээгээр өдөр тутмын амьдралдаа мэдэрч эхэлсэн гэдгийг судлаачид өгүүлж байна. Тэгвэл Африк тивийн Сахарын цөлийн бүсэд хагас тэрбум хүн усны гүн хомсдолд өртөж байгааг мөн дурьджээ.

Ус татралт, газар ашиглалт болон цаг уурын өөрчлөлт зэрэг нь дэлхийн

усны циклд сөргөөр нөлөөлж байна. Хэдийгээр баян орнууд устай холбоотой сорилтуудад ядуу орнуудыг бодвол арай илүү менежментээр хандаж буй ч 2050 он гэхэд есөн тэрбумд хүрэх дэлхийн хүн амыг хоол, хүнс, цэвэр усаар хангахын тулд усны менежментийн бодлогоо даруй шинэчлэх хэрэгтэй байгаа аж. Учир нь хүнсний үйлдвэрлэл цэвэр усны хамгийн том хэрэглэгч гэгддэг.

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудад цэвэр усны хангамж болоод бохир ус зайлуулах системийг түгээмэл болгох асуудлуудыг авч хэлэлцдэг. Гэвч устай холбоотой зарим түлхүүр ойлголтууд нүдэнд үл үзэгдэх хэлбэрээр орших нь олонтаа. Эдгээрийн нэг нь газрын гүнд эсвэл агаар мандалд “урсах” усны тухай байдаг.

Тэнцвэрийг олох тухайд

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудад тусгаснаар гадаргын цэнхэр ус, гол болон газар доорх гүний усны нөөц төдийгүй ногоон ус гэгдэх борооны усны нөөц хоорондын тэнцвэрийг олох нь тун чухал аж. Гэвч олон оронд ногоон ус ашиглах менежмент гэх зүйл байдаггүй ч усны асар том нөөц болдог. Иймд ногоон усыг хэрхэн хүртээмжтэй ашиглах тал дээр улс орнууд анхаарах цаг болжээ.


Гадаргын усны нөөцийг банкны данс гэж бодвол саяхныг хүртэл хүмүүс дансны үлдэгдлээ хэзээ дуусахыг мэдэхгүйгээр мөнгө зарлагдаж байлаа. Дэлхийн гадаргын усны нөөцийн ▶

► талаар бидэнд тодорхой мэдээлэл байсангүй. Одоо бол хиймэл дагуулаас авсан мэдээллийн тусламжтайгаар урт хугацааны явцад дэлхийн усны нөөц хэрхэн багасч буйг судлах боломжтой болсон юм. Ингэснээр дэлхийн 37 том усны давхаргын 21-ээс ундарч буй гүний усны гадагш урсах хэмжээ нөхөн сэргээгдэх хурдаасаа илүү их байгааг олж тогтоожээ. Тэгвэл мөсөн голуудыг бидний хадгаламж гэж төсөөлье. Өмнөд Америк, Азийн хэдэн зуун сая оршин суугч цас, мөснөөс хайлах усаар ундаалдаг. Гэтэл дэлхийн мөсөн голууд түүхэнд байгаагүй хурдаар хайлан алга болж байна. 2016 оны тавдугаар сард гарсан судалгаанд 2100 он гэхэд мөсөн голуудын 70-99 хувь нь эрчимтэй хайлж, ширгэх магадлалтай гэжээ. Улмаар эдгээрээс усаар хангагдах иргэдийн усны хэрэгцээ хязгаарлагдахад хүрэх төдийгүй хангамж тогтворгүй болох үед хүнсний аюулгүй байдалд аюул нүүрлэх эрсдэлтэй.

Цэнхэр усны хамгийн том хэрэглэгч нь хөдөө аж ахуй бөгөөд цэнхэр усны хэрэглээний 70 хувийг газар тариалангийн усалгаа эзэлдэг байна. Тэгсэн атлаа усалгаатай газар тариалан газар тариалангийн үйлдвэрлэлийн ердөө 34 хувийг бүрдүүлдэг бол хүнсний үйлдвэрлэлийн 66 хувийг ногоон усаар хангадаг аж. Өссөөр буй дэлхийн хүн амыг идэх хоолтой байлгахын тулд хүнсний үйлдвэрлэлийг 2050 гэхэд хоёр дахин нэмэгдүүлэх шаардлагатай. Гэвч усалгаатай тариалангийн тусламжтайгаар үүнийг хийх боломжгүй аж. Учир нь цэнхэр усны нөөц буурсаар буй төдийгүй хотуудын болон аж үйлдвэрүүдэд ихээр ашиглагдах цэнхэр ус экосистемийн нөхөн сэргээх явцад чухал үүрэг гүйцэтгэдэг. Иймд хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд ногоон ус түлхүү ашиглах болж байгаа юм. Ингэхийн тулд борооны ус, гадарга дээрх усны нөөцийг нэмэгдүүлэх зорилго бүхий усны менежментийг хэрэгжүүлэх нь чухал.

Жилд 840 мянган хүн цэвэр, баталгаатай ундны усгүйн улмаас амь насаа алддаг аж. Гэтэл дэлхийн зарим оронд суултууртаа цэвэр ус урсгаж байна. Түүнчлэн 2.5 тэрбум хүн бохир ус зайлуулах системгүй орчинд амьдарч байгаа юм. Хөгжиж буй орнуудад гарч буй өвчлөлийн 80 орчим хувь нь цэвэр усны хүртээмж болон бохир ус зайлуулах систем хангалтгүй байгаагаас үүдэж тархаж байгааг эрдэмтэд сануулдаг. Тэдгээр орны аж үйлдвэрийн

Цэнхэр усны хомсдол



боловсруулаагүй хог хаягдлын 70 хувь нь цэнхэр усны эх үүсвэр болох гол, мөрөн рүү цутгагддаг байх жишээтэй. Үүний үр дагавар одоогоор бидний нүдэнд үл үзэгдэж, далд хэлбэрээр аюул дагуулж байгаа юм. Тодруулбал, өндөр концентраци бүхий эмийн бүтээгдэхүүн, микро хуванцар хаягдлууд усанд агуулагдах органик нэгдлүүдтэй урвалд орж хэрхэн өөрчлөгдөж байгааг тогтооход улам бэрх болж байна.

Усны асуудалд ачаа болж буй бас нэг том эрсдэл бол ой мод ихээр устаж буй явдал. Өмнөд Америкийн газар нутгийн дайтай талбайд дэлхий нийт тариалан эрхэлж, Африкийн нийт нутаг шиг газарт мал маллаж буй. Газрыг ийн ашиглаж байгаа нь усны уурших түвшинд өөрчлөлт бий болгон агаар дахь усны хэмжээнд мөн нөлөөлж байна. Улмаар бороо орох төлөвт сөрөг өөрчлөлт бий болгож ган тохиох, ой мод хатаж устах нөхцөл үүсгэж байгаа юм. Өдгөө дэлхий дээр ургаж буй ургамлууд борооны түвшний 20 хувийг бүрдүүлдэг. Иймд ой модыг хамгаалах нь хотууд төдийгүй дэлхийн хөдөө аж ахуйн бүс нутгуудад орох борооны хэмжээг хэвийн хадгалахад дэм болно.

Зорилгод хүрэх зам

Дээрх мэт нүдэнд үл үзэгдэх ч амьдралд амин чухал асуудлуудыг шийдвэрлэхийн тулд харилцан нөлөө үзүүлэхүйц хэлбэрээр системчлэх нь чухал ажээ. Дэлхийн хэмжээнд яригдах ядуурал, хүнсний хомсдолыг үндсээр нь таслан зогсоохын тулд ногоон усны ашиглалтыг менежментээр зохицуулах, хувьсан өөрчлөгдөж буй экологийн тэнцвэрийг тогтворжуулахын зэрэгцээ гадаргын усны тогтвортой, хариуцлагатай хэрэглээг хангах хэрэгтэй аж. Зорилгот, бие даасан хандлага урьдчилан тооцоогүй үр дагаварт цохилт үзүүлэх хэдий ч нэгдмэл байр сууринаас хандах нь дээрх зорилгууд биеллээ олох боломжийг улам нэмэгдүүлнэ. Иймд зорилгуудыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн нэгдсэн цогц индикаторуудыг боловсруулах шаардлагатай хэмээн эрдэмтэн, судлаачид анхааруулж байна. ■

Эх сурвалж:
Дэлхийн эдийн засгийн форум

Хөдөө аж ахуй

Тэнгэр харсан тариалан

Б.ҮҮРИЙНТУЯА

Өнгөрсөн жил нэлээд халуун зун болсон. Энэ жил ч мөн халах төлөвтэй байгааг Хүнс, хөдөө аж ахуйн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Б.Одонхүү хэлсэн юм. Дэлхийн хамгийн халуун жил гэж бүртгэгдсэн 2015 он манай улсын газар тариалангийн салбар байгаль эхэд найдаж болохгүй гэдгийг харуулсан. Газар тариалангийн гол бүс нутаг болох Дархан, Сэлэнгийн тариан талбайд өвдөг хүрэхгүй өндөртэй, гандаж, хорчийсон тариа зонхилж байв. Өнгөрөгч онд ургацынхаа 80 хувийг алдлаа гэх сургаар гурил, ногоогүй болох нь гэсэн шуугиан гарсан. Бодит тоогоор бол 262.6 мянган тонн үр тариа, үүнээс 203.9 мянган тонн буудай хураан авсан талаар Б.Одонхүү ярих. Нар, салхи, бороо хур нь “таарвал” ахиухан ургац авч, нийслэлийн төв талбай дээрээ асгасан шигээ тэмцэл, цуглаан явуулж байсан нь хоёр хаврын өмнө. Гэтэл өнгөрсөн жил хэт халж, хур тунадас дэндүү бага орсноос асгах нь байтугай хадгалах ургацгүй шахам өнжив.

Уул уурхайн гэгдэж буй ч нэгэнтээ газар тариалангийн эдийн засагтай байсан манай улс 1990 оныг хүргэл усалгаатай газар тариаланг төлөвлөгөөтэй хөгжүүлэхэд анхаарч 1990 оны байдлаар 91.6 мянган га газар услах хүчин чадал бүхий 482 усалтын систем ашиглалтад оруулсан байжээ. Гэвч 2003 оны тооллогоор 29.1 мянган га газар услах ердөө 121 усалтын систем үлдсэн, бусад нь эвдэрсэн эсвэл тоногдсон гэсэн дүгнэлт гарсан байгаа юм. Тэгвэл 2015 он гэхэд дээрх тоо харьцангуй нэмэгдэж 350 гаруй усалтын систем ашиглалтад орсноор 54.1 мянган га-д усалгаатай тариалан эрхлэх болсон байна. Гэсэн ч энэхүү хүчин чадлыг одоогоор бүрэн ашиглахгүй байгаа нь талбайн агротехникийн онцлогоос хамаараад зарим жилд өнжих, сэлгэх зэргээс үүдэлтэй гэх. Усалгааны систем ил байдаг учраас эвдрэл, гэмтэл их. Түүнчлэн тариалангийн талбайг байнгын усалгаатай байлгах нь хөрсний үржил шим алдагдах, тодорхой хэмжээгээр бордохгүй бол ургацын хэмжээ буурах эрсдэлтэй байдаг аж. Эрсдэл бидэнд тулгамдсан том асуудал биш юм, одоохондоо. Манай улс жимс жимсгэнээ 100 хувь, хүнсний ногоо 90, төмсний 50 хувийг усалгаатай тариалангаас авч байна. Тэгэхээр хүнсний ногоо болон жимс жимсгэнийг усалгаагүй нөхцөлд тариална гэдэг ургацгүй байх эрсдэл гэдгийг Хүнс, хөдөө аж ахуйн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Б.Алтангэрэл хэлсэн. Түүнчлэн 2014 оны байдлаар 3800 га-д үр тариа усалгаатай тариалж, нэгжийн ургац 21.5 центнер хураан авчээ.

Усны нөөцийн хувьд манайх тийм ч дээгүүр бичигдэхгүй. Хойд бүс баруун, зүүн, говийн бүсийг бодвол усны эх үүсвэр ихтэй ч хангамжийн асуудал газар тариалангийн тухайн талбайн байрлалаас хамаарах аж. Зарим нөхцөлд жижиг, том

гол түшиглэх эсвэл гүний худгаас ус татах замаар байгалийн нөөцийг ашиглан усалтын систем барьж буй. “Бороо, цасны ус хуримтлуулах хөв цөөрөм буюу тариалангийн талбайн усан хангамжид ашиглах усны нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч байгаа” хэмээн Б.Алтангэрэл хэлсэн. Тодруулбал, Төв аймгийн Борнуур сумд байрлах нэг сая шоо метр ус бүхий усан санд (хиймэл нуур) яам хөрөнгө оруулалт хийж, улмаар 1000 орчим га тариалангийн талбайд усны эх үүсвэр болж байгаа аж. Гэсэн ч газар тариалангийн салбарт ус “нийлүүлж” ургацаа ахиулах шаардлага бий. Усны тухай хуульд зааснаар голын гольдролын



75 хувь нь урсах ёстой тул үлдсэн 25 хувийг газар тариаланд ашиглахын зэрэгцээ хавар, намрын шар усны үерийн усыг мөн ашиглах боломж бий. Гэвч гадаргын усны нөөц бүрдүүлэн хадгалах усан санг барих боломж хомс байгааг Б.Алтангэрэл дурьдсан.

Баталгаатай, тогтмол ургац

Монгол Улсын хэмжээнд газар тариалангийн нийт эргэлтийн талбай нэг сая га орчим байгаагийн 800 мянга орчим га талбайг ашиглаж байгаа бол үүний 400 мянган га орчмыг усалгаатай болгох боломж байгаа аж. Инженерийн хийцтэй усалтын системүүдийг барьж байгуулах нь ихээхэн хэмжээний хөрөнгө шаардах тул нарийн төлөвлөгөөний дагуу ажиллах ёстой юм байна. Өмнө нь санхүүжилтийн асуудлыг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдэх эсвэл яамны зүгээс тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлж байж. 2003-2013 онд буюу 11 жилийн хугацаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн болон орон нутгийн ▶

► өмчлөлийн 350 гаруй услалтын системийг сэргээн засварлаж, шинэчилж, шинээр байгуулахад улсын төсвөөс 33.2 тэрбум төгрөгийн, хувийн хэвшлээс 18.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бол гадаадын төсөл хөтөлбөрөөс 343.7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж жижиг услалтын системийг засварлаж, усалгааны тоног төхөөрөмж олгожээ. Ийнхүү байгалийн эрхшээлээс харьцангуй хараат бус явах усалгаатай газар тариалангийн эрчимжсэн үйлдвэрлэлд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ эрс нэмэгдсэнээр усалгаатай талбайн хэмжээ 6-7 дахин өссөн. Гэвч 2012 онд Төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хувь хүн болон иргэн, аж ахуйн нэгжид хөрөнгө оруулахыг хориглосон учир усалгаатай тариалангийн хөгжилд том саад болж байна. Далайн түвшнөөс 1500 гаруй метрийн өндөрт орших хуурай уур амьсгалтай Монгол Улсад усалгаатай газар тариаланг хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай гэдгийг өнгөрсөн зуны хэт халалт харуулсныг ургацаа алдсан тариаланчид төдийгүй төрийн албаныхан ч хэлсэн. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр услалтын систем барьж байгуулах ажлыг шийдвэрлэж болох ч одоогоор энэ тал дээр хэрэгжсэн томоохон төсөл, хөтөлбөр алга байна. Яам нэгэнт төрийн болон орон нутгийн өмчийн хүрээнд л хөрөнгө оруулах хязгаартай учир хувийн хэвшлийнхэн усалгаатай тариалангийн талаар тус гуйж яам руу зүглэхийн ч хэрэггүй болжээ. Иймээс мөнгө санхүүгийн асуудалдаа маш хянамгай хандаж, хамгийн зөв шийдэлд хөрөнгө оруулах хэрэгтэй. Энэ нь хөрс, усны хайгуул, судалгааны ажлуудад үндэслэн услалтын системээ байгуулна гэсэн үг. Хэт халалтын үед жижиг гол, горхи ширгэх эрсдэлтэй. Нөгөө талаар хайгуул, судалгаа сайн хийгээгүйн улмаас үржил шимгүй хөрстэй талбайд усалгааны байгууламж барьчихсан тохиолдол бас байдаг аж. Иймд усны барилга байгууламж буюу гедротехникийн инженер, гедротехникч, агротехнологич зэрэг мэргэжилтэнг бэлтгэх асуудал чухал байгаа юм. Усалгаатай газар тариалангийн үнэ цэнийг мэдрэхийн хэрээр дээрх чиглэлүүдээр боловсон хүчин төрөн гарч буй ч салбарыг хөгжүүлэхүйц хангалттай хэмжээнд хүрэхгүй байгааг Б.Алтангэрэл онцоллоо.

Мөнгө байвал

Өрийн тааз нь тавцан болчихсон Монгол Улсад асуудал дэвшүүлж, дэлгэх болгонд л мөнгө байвал, санхүүжилт шийдэгдвэл гэсээр бишгүй олон жилийг үдэв. Энэ хооронд үндэсний аюулгүй байдалтай холбоотой бүх салбар үндсэндээ дампуурчээ. Жишээ нь эрүүл мэндийн салбар “нисгэгчгүй онгоц” болж зорчигчид (иргэд) нь аврал хайж байна. Боловсролын салбарт олон улсын олон туршлага орж, гардгаараа муу нэр зүүх болсон. Уул уурхайн салбар модоо барьчихлаа. Араас нь хөдөө аж ахуйн хувь тавилан бас л хүнд байгаа гэж буй. Учир нь өнгөрсөн жилийн хэт халалтын улмаас ургац хураалт багагүй хувиар буурсан бөгөөд хэрэв усалгаатай тариаланг хөгжүүлсэн бол зорилтот төлөвлөгөөндөө төвөггүй хүрчих байжээ. Тодруулбал, 2015 онд ургац алдсан тул 2016 оны үрийн асуудал хүндэрсэн. Үрийн нөөц бүрдүүлэлт 20 мянга орчим тонноор дутсан, үүнийг нөхөх санхүүжилтийг бий болгох тал дээр дорвитой алхам хийх боломжгүй байгааг Б.Одонхүү онцолсон. Түүнчлэн аж ахуйн нэгжүүд бие даан 2016 оны тариалангийн үйлдвэрлэлээ хэвийн аваад явах санхүүгийн чадамж муу байгаа юм. Тэгвэл 1988 онд манай улс 31.1 мянган тонн улаан буудай экспортолж байсан түүх бийг Дэлхийн хүнс, хөдөө аж ахуйн байгууллага /FAO/-ын “Хөдөө аж ахуйн статистик-2014” мэдээллээс харж болно.



Нэгэнт цаг уурын “аашийг” номхотгож чадахгүй учраас байгалиас хараат байдлаа багасгах, тухайлбал хаврын тариалалтын технологийн ажлуудын бэлтгэлийг сайтар хангах хэрэгтэй. Яамны зүгээс уринш тариалах зөвлөмжийг эхний ээлжинд гаргасны зэрэгцээ хэт халалт болох магадлал өндөр байгааг харгалзан тариалах хугацаагаа тооцох нь чухал гэсэн юм.

УИХ, Засгийн газраас Газар тариаланг тогтмолжуулах богино хугацааны хөтөлбөр гарган хоёр жилийн хугацаатай 100 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг шийдэх ажлыг Хөгжлийн банкинд зөвшөөрчээ. Яамны зүгээс энэ жилийн газар тариалангийн үйлдвэрлэлд шаардлагатай арга хэмжээ зэргээ тооцоод судалгаа, дүгнэлтээ тус банкинд хүргүүлсэн гэдгийг Б.Одонхүү дуулгав. Тэрбээр “Хөгжлийн банк 100 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг хаанаас гаргах тухайгаа шийдвэрлэх ёстой. Тэгээд ямар хүүтэй зээл гаргахаа тодорхойлох. Энэ даруй шийдэгдвэл тариалалтад ямар нэг санхүүгийн хүндрэл гарахгүй байх боломж байна. Үгүй бол тариалалт маш хүнд болно” гэв. Энэ асуудлыг Хөгжлийн банкнаас тодруулах гэсэн ч “Шийдэгдээгүй, хариу гарвал мэдээлнэ” гэхээс өөр зүйл хэлээгүй юм. Тэгэхээр санхүүжилттэй холбоотой асуудлууд энэ жил мөн л төвөг удаж мэдэхээр байна.

Хөдөө аж ахуйн сайд асан Ш.Гунгаадорж гуайн хэлж байгаагаар мөнгө бол шалтаг төдий зүйл ажээ. Тэрбээр Монгол Улс усны нөөцийн хувьд боломжийн төдийгүй бороо, цасыг ашиглан нөөц бүрдүүлэх нь “үнэгүй” эх үүсвэр гэдгийг чухалчилсан. Харамсалтай нь зарцуулах ёстой зүйлдээ хөрөнгө зарахгүй атлаа санхүүжилтгүй хэмээж буйг шүүлжилсэн юм. Манай улсад 1990-ээд оны өмнө ашиглаж байсан усалгааны олон систем бий, тэдгээрийн сэргээн засварлалтыг харьцангуй бага хөрөнгөөр шийдэж болох тухай дурьдсан юм. Түүнчлэн шар усны үерийн амыг тосох маягаар ус хуримтлуулах сан барих боломж бүрэн бий гэдгийг жишээ болгон тайлбарлалаа. Газар тариалангийн үйлдвэрлэлийн байгалиас хараат байдлыг буруульа гэвэл усалгаа зайлшгүй хэрэгтэй гэдгийг ганц Гунгаадорж гуай биш, газар тариалангийн салбарынхан онцолж буй юм. Гагцхүү ингэхдээ жижиг чулуугаар том чулуу хөдөлгөдөгийн адилаар орон нутгийн удирдлагуудаас эхлээд хаа хаанаа санаачилга, идэвх зүтгэлтэй ажиллах учиртай аж. ■



Хэрвээ ингэвэл яах вэ

Дэлхий 2016 жилийн дугаарыг дагуулан The Economist сэтгүүл “Хэрвээ ингэвэл яах вэ” гэсэн хувилбарууд дэвшүүлснийг бид дугаар бүртээ цувралаар хүргэж байна

Улс төр

Хэрвээ Орос задарвал



Путины ард буй аюул

Владимир Путин ерөнхийлөгчийн засаглал дор, Орос улс нь гадаад ертөнцөд Зөвлөлт Холбоот улсын үед өөртөө нэгтгэж байсан газруудыг эргүүлэн олж авч, хүчирхэг хаант улс дахин босгох гэж оролдож буй түрэмгийлэгч шиг харагдаж байгаа. Гэтэл 200 гаруй үндэстнийг багтаасан, газар нутаг нь 11 цагийн бүсийг хамардаг Орос өөрөө дотроосоо задран унаж байвал яах вэ?

Энэ бол Орос анх удаа хүчирхийлэл, газар нутгаа тэлэх оролдлого хийх замаар орчин үеийн чиг хандлагын эсрэг тэмцэх гэж үзээд эцэстээ өөрийн улс орны нэгдмэл байдлыг алдаж байгаа нь биш юм. Орос улс 1904 онд хувьсгалын ирмэг дээр тулж ирэх үед Николас II үндэсний урвагчдыг хайж олох мөн Японтой багахан дайн эхлүүлэх замаар өөрчлөлтийг саатуулахыг оролдож байсан. Дайн жилийн дараа Оросын ялагдлаар төгссөн бөгөөд үүнээс 12 жилийн дараа Оросын царьт хаант улс хэдхэн өдрийн дотор нуран унасан юм. Харин 1979 онд Коммунист удирдлага өөрсдийн асуудлуудаас бусдын анхаарлыг зайлуулахын тулд тэр үед Зөвлөлт Холбоот Улс Афганистан руу дайрсан: 12 жилийн дараа Зөвлөлт Холбоот Улс гэв гэнэт задарсан.

Москва хотын дундаж амьдралтай иргэд 2011 онд гудамжинд гарч, шинэчлэлийг шаардсан. Ноён Путин үндэсний

урвагчид гэх гүтгэгдсэн хүмүүсийг яллаж, Крымыг эзэлж, Украины эсрэг дайн эхлүүлсэн. Оросын сүүлийн үеийн гадаад бодлого өмнөхүүд шигээ төгсгөлд—Төр ба улсын задралд-хүргэж мэднэ гэх санаа тийм ч боломжгүй зүйл биш.

Зөвлөлт Холбоот Улс хүчээ хэт тарамдуулж, санаа болон мөнгөө үрээд дуусгачихсан учраас задарсан. Бүс нутгийн удирдагчид дампуурсан улсын нэг хэсэг байх нь ашиггүй гэж үзсэн. Нүсэр том улсыг бүрдүүлж байсан 15 улс хилийн зурвасаараа салан тусгаарлацгаасан.

Гэвч энэхүү задралын үйл явц яагаад цаашаа үргэлжлэлгүй зогсонд том шалтгаан байдаггүй. Үнэндээ Оросын олон бүс нутаг тухайлбал Сибирь, Урал, Карелия, Татарстан тухайн үедээ “тусгаар тогтнолоо” зарласан байдаг. Оросын энэхүү задралыг цааш нь даамжруулахгүйн тулд ерөнхийлөгч Борис Ельцин холбооны улс гэх санааг сэдэж, улс бүрт өөрийнх нь эдлэх хэмжээнд тусгаар тогтнолыг амласан. Тусгаар улс шиг онцлогуудыг олж авсан Татарстаны эртний нийслэл Казанд Ельцин амлалт өгсөн: ерөнхийлөгч, үндсэн хууль, туг, хамгийн чухал нь өөрийн гэсэн төсөвтэй байх эрх. Үүний хариуд Татарстан Оросын нэг хэсэг болон үлдэхээр амласан юм.

Ноён Путин холбооны улсын зарчмыг хаяж, Оросыг төвлөрсөн засаглалтай орон болгосон. Тэрбээр бүсийн сонгуулиудыг үгүй хийж, ерөнхийлөгчийн төлөөлөгчийг бүс нутгийн дарга нарыг захируулахаар

томилж, Москвагийн эрх ашгийн төлөө татварын орлогыг дахин хуваарилсан. Гэвч тэрбээр бүгдийг хамрах нэгдсэн тогтолцоог бий болгоогүй. Орос улс хууль сахиулагч бус шударга бус явдал авилгалын үүр уурхай гэж үзэгдэж буй.

Түүхч Михайль Ямпольскийн хэлснээр бол одоогийн Орос нь Кремлийн их хаанаас захирах эрх авдаг ханхүү нартай хаант төр шиг байдаг. Сүүлийн 10 жилд Москвагаас томилсон засаг дарга нарын гол ажил нь ноён Путиний төлөө хүмүүсийг санал өгүүлэх байж ирсэн. Үүний хариуд тэд газрын тосны ашгаас тодорхой хэмжээг хүргэж, тохирох газраа хүссэнээрээ захирах эрхтэй болдог.

Үүний тод жишээ нь ноён Путиний Чеченьд томилсон цэргийн дарангуйлагч асан Рамзан Кадыров. Хамгийн сүүлийн ерөнхийлөгчийн сонгуульд Чеченьд нийт иргэдийн 99.6 хувь нь сонгууль өгөхөөр ирснээс 99.7 хувь нь саналаа ноён Путинд өгсөн байдаг. Эргээд хариуд нь ноён Кадыров татаас авч, өөрийн иргэддээ “албан бус” татварууд ногдуулж, Исламын дэглэмээр захирах эрх олж авсан. Ноён Кадыров Оросын нэг хэсэг болон жүжиглэж, Путинд үнэнч гэж амласнаар Москва дарангуйллын засаглалтай, авлигад автсан Чеченьд өндөр төлөөс төлдөг.

Хэрвээ Путин явж, мөнгө дуусвал, Чечень хамгийн эхэнд салан тусгаарлах улс нь байж мэдэх. Энэ нь хойд Кавказын үндсэн бүс нутагт огцом нөлөө үзүүлнэ. Хөрш зэргэлдээ харьцангуй том газар нутагтай мөн илүү цогц муж болох Дагестан нь мөн салан тусгаарлаж мэдэх юм. Кавказ дахь зөрчилдөөн Оросын төв засгийн газрын сулралтай нийлбэл, бусад бүс нутгийг ч Москвагийн асуудлуудаас өөрсдийгөө салгахыг хүсэхэд хүргэж магадгүй.

Муслим шашинтай хоёр сая татар иргэн ба 1.5 сая оросуудын өлгий Татарстан нь өөрийгөө XV зуунд байсан шигээ тусгаар хаант улс хэмээн зарлаж мэднэ. Энэ улс нь өөрийн гэсэн үндэсний хүчтэй үзэлтэй мөн газрын тосны фирм, өндөр боловсролтой удирдагчдын анги давхраа бүхий төрөлжсөн эдийн засагтай. Улмаар тус улс нь Крымтэй онцгой харилцаа бүрдүүлнэ. Крымын тартарууд нь (түүхэнд олон жил өөрсдийнх нь газар байж ирсэн нутагтаа) тусгаар улс болсноо зарлана.

Уралын бүс 1993 онд оролдлого хийж байсан шигээ Оросын дөрөв дэх хамгийн том хот Екатеринбургт төвөө байршуулан тусгаар улс болж магадгүй. ▶

▶ Эсвэл Сибирьтэй хоршиж, холбоот улс байдлаар гарч ирж болох юм. Сибирь өөрийн гэсэн үндэсний үзлээ сэргээж, ач холбогдол бүхий хотуудаа Красноярск болон Эрхүү болгож, газрын тос, хийн баялгийг өөрсдийн гэж зүтгэн авч, Хятад руу зарж мэдэх юм. Оростой адилгүйгээр Хятадад Алс Дорнод болон Сибирийн цөөн хүн амтай, алс бөглүү газрууд руу өөрийн нутгаа тэлэх сонирхол төдийлэн байхгүй ч тус улс эдгээр бүсүүдийг эдийн засгийн хувьд колоничилж (одоо ч ингэж байгаа) мэдэх юм. Алс Дорнодын хамгийн том хоёр хот болох Владивосток болон Хабаровск нь Оросын Европ хэсгүүдээс илүүтэй Өмнөд Солонгос болон Хятадтай эдийн засгийнхаа хувьд илүү гүн сүлбээтэй.

Цөмийн зэвсэг агуулагчид салан одно

Америк Оросыг задлахыг оролдож байна гэх Оросын хардлагыг үл харгалзан, ямар ч хувилбар байлаа гэсэн барууныхны хувьд хамгийн муухай хар дарсан зүүднүүдийнх нь нэг. Энэ нь Оросын цөмийн зэвсгүүдийн хяналт хэнд байх тухай асуултыг гаргаж ирж буй юм. Хэдийгээр тушаал өгөх төв Москвад үлдэх ч, Оросын бүс нутгуудаар тарж байршсан зэвсгүүдийг зөөх нь Зөвлөлт Холбоот улс задарсны дараах үед хийснээс ч хэцүү байх болов уу. Тэр үед оросууд болон америкчууд хамтдаа цөмийн зэвсгийн нөөцийг Украин, Казахстанас Орос руу нүүлгэн шилжүүлэх тал дээр амжилттай ажилласан. Будапештийн санамж бичиг хэмээн нэрлэгдсэн баримтад Орос, Америк болон Британи гарын үсэг зурж Украинд өгсөн. Энэ нь цөмийн зэвсгээ нутаг дэвсгэрээсээ гаргасныхаа төлөө газар нутгийнхаа нэгдмэл байдлыг хадгалж үлдэх баталгаа болсон. Оросын Крымыг бүрэлдэхүүндээ оруулсан нь үүнээс хойш тус улс ямар ч амлалт өгсөн хэн ч итгэхээргүй болголоо.

Ялзралын хий үзэгдэл Оросоор тэнэж явна. Улс төрчид болон мэргэжилтнүүд олон нийт дунд хэлэлцэхээс айж байна. Крымыг эзэлж, зүүн Украинд салан тусгаарлах үзлийг өдөөсний дараахан Кремлин “Оросын газар нутгийн нэгдмэл байдлыг сулруулах оролдлого бүхий ямар ч өдөөн турхирсан үйлдлийг” эрүүгийн гэмт хэрэг гэж үзнэ гэх утга бүхий хуулийг танилцуулсан. Гэвч Оросын газар нутагт учирч болох хамгийн том заналхийллийг Кремлин өөрөө болон түүний Украин дахь бодлого бий болгож байгаа.

Зөвлөлт холбоот улсын дараа бүрэлд-

сэн хилийн шугамуудыг эвдсэнээр, ноён Путин үр дагаврыг нь төсөөлөх боломжгүй үйл явцыг эхлүүлсэн. Хэрэв Крым түүхэндээ түүний хэлсэнчлэн Орост харьяалагддаг юм бол Калининград буюу хоёрдугаар дайны дараа Орост алдсан Германы Кёнингсберг яах юм бэ? 1940 оны өвлийн дайны дараа Зөвлөлт Холбоот улсад буулт хийн өгсөн Финляндын зүүн Карелиа Финляндад эргэж очих ёстой биш үү мөн Курилийн арлуудыг Японд буцааж өгөх ёстой биш гэж үү.

Оросын ирээдүйд илүү аюултай нь, ноён Путин үндсэрхэг үзэл, дайнд суурилсан хүчин зүйлсүүдийг хөдөлгөсөн. Эдгээр нь хаант засаглалын газар нутгаа тэлэх хүчин зүйлс биш. Орос улс нь эзэнт

гүрэн байгуулахад шаарддаг алсын хараа, динамик хөдөлгөөн, эх сурвалжуудын хувьд дутагдалтай. Эдгээр дайн, үндэсний үзэлд суурилан хөдөлгөсөн хүчнүүд нь эмх замбараагүй байдлын эх сурвалж. Зүүн Украин нь өдгөө гэмт хэрэгтнүүд болон гэмт бүлэглэлүүдийн үүр болон хувирсан. Тэд Оросын соёл иргэншлийг түгээж чадахгүй харин хууль ёс, засаглалгүй байдлыг тарааж чадна.

Товчхондоо, Путиний Орос харагдаж байгаагаасаа хамаагүй илүү хэврэг. Түүний Тамгын газрын орлогч дарга Вячеслав Володин саяхан Путинийг Оростой эн зэрэгцүүлж, “Путин үгүй бол Орос үгүй” хэмээн хэлсэн. Энэнээс муу ял тулгалт гэж юу байхав. ■

Хэрвээ НАТОгийн гишүүн дайралтад өртвөл

Итгэлцлийн гэрээ



Барууныхан Оросын давшилтыг хэрхэн хүлээж авч, ямар хариу үйлдэл үзүүлэх вэ

Украин дахь Оросын түрэмгийлэл НАТО-д шинэ заналхийлэл, шинэ зорилго бий болгож өгсөн: Тэр нь “hybrid warfare” буюу холимог дайн. Холбоотнуудын зэвсэгт хүчний шинжээчид байж болох хямралын хувилбарууд дээр нарийвчилсан нууц төлөвлөгөөнүүд боловсруулж байна.

Крымыг өөртөө нэгтгэж, Украины Донбас (Донецкийн сав газрыг) бүсийг задалсан Оросын Ерөнхийлөгч

Владимир Путин илүү амбицтай зүйл рүү хөдөлж эхэлнэ гэх таамаг бол хамгийн түгээмэл нь. Түүний зорилго: Оростой хиллэдэг Балтийн тэнгисийн хоёр улс Латви, Эстонид Украинаас хуримтлуулсан холимог дайны туршлагаа хэрэгжүүлэх замаар НАТО болон Европын холбооны нөлөөг бууруулах.

Байнд онилсон улсыг мохоож болох цэргийн ба цэргийн бус хэрэгслүүдийг холимог дайн нэг дор ашигладаг. Балтийн тэнгисийн улсууд нь Украинтай адилгүй ба Европын Холбоо болон НАТО-ийн гишүүн мөн 1949 ▶

► оны Вашингтоны гэрээний Тавдугаар зүйлийн дагуу цэргийн холбоотнууд хамтдаа аюулгүй байдлаа хангах үүрэг хүлээсний дагуу хамгаалагдах эрхтэй. Тавдугаар зүйлд нэг улс руу нь дайрвал, бусад улс руу нь дайрсанд тооцно гэсэн байдаг. Гэхдээ энэ зүйл заалтыг аливаа улс цэргийн дайралтад орсон эсэх нь эргэлзэх зүйлгүй ойлгомжтой байсан тэр үед оруулж ирсэн байдаг. Тиймээс одоо урган гарч буй том асуулт нь тодорхойгүй байдал, няцаалт ашиглаж үнэхээр дайрах гээд эсвэл дайраад байгаа эсэхийг хэлэхэд хэцүү XXI зууны Оросын тактикийн учрыг олоход дээрх гэрээний зүйл тохирох уу гэдэг байна. НАТО-ийн 66 жилийн түүхэнд Тавдугаар зүйлийг зөвхөн нэг л удаа буюу 2001 оны есдүгээр сарын 11-ний халдлагын дараа хэрэгжүүлэх шаардлага гарсан. Тэр

хамт тулалдах уриалагт автан Украинд очсон Эстони болон Латвид амьдардаг орос үндэстнүүд гэртээ эргэн ирж дайнаа үргэлжлүүлж болох юм.

Нөхцөл байдал дордоод ирэнгүүт, ноён Путин элит цэргийн хүчээ Оросын талын хил дээр сэмхэн сургуулилтнууд хийхийг тушаах бөгөөд ингэснээр түүнд гэнэтийн тушаалаар цэргээ оруулах боломж бүрдэнэ. Ийм төрлийн цэргийн сургуулилтнууд Украиныг үймүүлэхэд чухал элемент болсон байдаг. Кибер халдлага ихсэх нь төөрөгдлийг улам нэмэгдүүлж, Оросын нисэх хүчин холбоотон улсын агаарын орон зайд зөвшөөрөлгүй хүч түрэн нэвтрэх нь үлэмж хэмжээнд олшрохыг НАТО харах болно. Дараа нь Крымд гэнэт гараад ирсэн шиг цол тэмдэггүй ч цэргийн дүрэмт хувцас өмссөн “Ногоон эрс” гэх өөрийгөө хамгаалах хүчнүүд

хэлэлцээрээр энэ асуудлыг зохицуулах Германы ятгалга нь дэмжигчдийн саналыг түлхүү авна. Тиймээс НАТО-гийн итгэл хүлээдэг гол мөн чанар, мөн уг төсөөлөл дээр тогтдог Европын аюулгүй байдлыг шалгах цаг ирэхэд итгэлцэл дутаж, үнэн төрх нь харагдана.

Тийм ч хурдан биш шүү, Владимир

Энэ бүхэн тохиолдох магадлал хэр өндөр вэ? Магадгүй Путин НАТО-той тэмцэлдэх нь хэтэрхий эрсдэлтэй гэж үзэж болох. Түүний Украин дахь эрсдэлтэй адал явдал хүртэл Оросын цэргийн хүчний эх сурвалжийг тарамдуулчихсан.

Гэвч холбоотнууд зөвхөн үүнд найдаад тайвширчихгүй. Тэд НАТО-гийн Хариу Цэргийн хүчийг бий болгох төлөвлөгөөнүүдээ бэлдэж үүнийхээ дагуу сайн зэвсэглэсэн 40.000 дайчныг өндөржүүлсэн бэлэн байдал байлгаж буй. 5000 цэргээс бүрдсэн толгой хүч нь асуудал дэгдсэн эхний дохиогоор магадгүй хэдхэн цагийн дотор улс төрийн нэгдсэн зөвшөөрөл шаардахгүйгээр холбоотнуудын дээд ерөнхий командлагч генераль Филипп Бридловийн тушаалаар хөдлөхөд бэлэн байна. НАТО-гийн шинэ Ерөнхий нарийн бичгийн дарга Энс Штолтенбэргийн зүгээс энэ нь мөн тэргүүн шугаманд байгаа орнууд тагнуулын мэдээлэл цуглуулах ажиллагаа болон нөхцөл байдлын үнэлэлт дүгнэлтээ сайжруулахад тусалж буй гэж хэлж байна. Түрэмгийлэгч юу төлөвлөж байгааг мөн нөхцөл байдал ямар шатанд байгааг эрт таньж ойлгох нь нэн чухал.

НАТО-ийн батлан хамгаалах бодлогын нарийн бичгийн даргын туслах Хайнрих Браус хурдтай шийдвэр гаргах шаардлагыг онцолж буй: “Холимог дайралтын үед долоо хоног гэдэг хэтэрхий урт байж мэдэх юм. Бид өдгөө үе шатуудаа харьцангуй хурдтай болгож буй” хэмээн тэрбээр хэлж байна. Тэрбээр ямар нөхцөл байдал, хэм хэмжээ Тавдугаар зүйлд заасан ажиллагааг хэрэгжүүлэхэд хүргэх вэ гэдгийг тайлбарлахаас татгалзсан. “Зарим зүйлийг тодорхойгүй байлгах шаардлагатай” хэмээн үүнийг тайлбарлалаа. Гэвч дайсан “НАТО ямар нэг арга хэмжээ авах чадвартай мөн бэлэн байгаа гэдгийг мэдэх хэрэгтэй” гэж мөн Хайнрих Браус хэллээ. ■



Зургийн тайлбар

үед ч холбоотнуудын хамгийн хатуу ташуурыг тухайн нөхцөлд ашиглах нь зохистой эсэх маргаан дэгдсэн.

Энэ жишгээр ноён Путин туршилт хийж мэдэх юм. Оросын аль хэдийнэ стратегийг нь боловсруулчихсан тоглоомынхоо дагуу, Эстони болон Латви дахь оросуудыг (тус хоёр улсын хүн амын гуравны нэг нь орос гэдгийг тооцоолон) ялгаварлуулж байна гэх ухуулга сурталчилгаагаар “нүдэж” эгдүүцлийг нь өдөөж асуудлыг эхлүүлнэ. Нийслэл хотууд Рига болон Таллинд Оросын төлөөх бослого үймээнийг гаргах төлөөлөгч, өдөөн хатгагчдыг ашиглах зэргээр Орос дээрх хоёр улсын эрх мэдэлтнүүдийн нэр нөлөөг унагах гэж чадах бүхнээ хийнэ. Зүүн Украинд “ах нартайгаа”

орос үндэстнүүд ихтэй газруудаар байгуулагдаж эхэлнэ.

НАТО-гоос Тавдугаар зүйлд заасан үйл явдал болох гэж буйг зарлахыг Эстони болон Латви шаардаж улмаар холбоотон орнууд тэднийг хамгаалах үүргээ биелүүлэхийг хүснэ. Гэвч энэ нь нэг талаас бүрэн хэмжээний хариу арга хэмжээ авах тохиолдол мөн үү гэдэг эргэлзээ бий болгож, нөгөө талаас хэрвээ НАТО ямар нэг зүйл хийвэл Орос өөрийгөө хамгаалахын тулд цөмийн зэвсэг хэрэглэхэд хүргэнэ гэдэг анхааруулгыг Путин өгч болох юм. Тиймээс холбоотны “их хурал” гэж хэлж болох Хойд Атлантикийн консул шаардагдах 28 улсын саналыг авч нэгдмэл байдалд хүрч чадахгүй. Европт том дайн өдүүлэхээс өмнө улс төрийн

Хууль

Зээлийн гэрээ: Хоёр үнэний хооронд

Ц.ЭЛБЭГСАЙХАН

Иргэд хоорондоо хүүтэй мөнгө зээлүүлэхийг хуулиар хориглосон тухай мэдээлэл өнгөрсөн сард гарч олон хүнийг гайхашруулав. Зарим нь бүр Шаритын хуультай адилтгаж байна. Харин нөгөө талд ерөөс иргэд хооронд зээл гэж зүйл байх ёсгүй. Энэ бол хараа хяналтгүй, зохих ёсны татвар суутгалгүй далд эдийн засгийг буй болгодгийн дээр хүүг бодитой бус тогтоож нэг нь нөгөөгөө шулан мөлжиж буй хэлбэр хэмээн үзэх эдийн засагчид бий. Хамаг асуудал өнгөрсөн оны арванхоёрдугаар сарын 3-нд Иргэний хуульд оруулсан нэмэлтээс эхтэй. Уг хуулийн 281 дүгээр зүйлийн гурав дахь заалт “Зээлийн гэрээ нь хариу төлбөргүй байна” гэжээ. Үүний “хариу төлбөр” гэдгийг хүү хэмээн ойлгоно гэж “Отгонтэнгэр” их сургуулийн багш хуульч Р.Очирбал тайлбарлаж буй. Хуулийн энэ заалт ирэх есдүгээр сарын 1-нээс хэрэгжих юм.

Улсын дээд шүүхийн 2006 оны 53 дугаар тогтоолд тайлбарласнаар “үндсэн хүү гэж... гэрээнд заасан хэмжээгээр төлөх хариу төлбөр буюу зээлийн үнийг хэлнэ” гэжээ. Үүнийг үндэс болговол иргэд хоорондоо ямарч тодорхой нөхцөлтэй гэрээ байгуулсан хүү нэхэх боломжгүй болно. Хэдэн төгрөг зээлүүлсэн түүнийгээ л буцаан авч чадна гэсэн үг.

Гэхдээ энэ бүхэн нь амьдралд хэрхэн хэрэгжих вэ гэдэг чухал. Хүү болон бусад төлбөрийг хориглосноор хуулийг “зальдах” арга ухаан сийлж эхэлдэг байна. Ислам шашинд мөнгө хүүлэхийг нүгэл гэж үздэг. Хүндэтгэдэг шашны хуулиар нь хориглосон байлаа ч зах зээлийн бодит харилцаанд хэрхэн орох аргаа Арабууд олсон юм. Тэд мөнгийг зээлэх бус түрээслэх болжээ. Тухайлбал “Ислам бонд” гэгддэг Sukuk гэх санхүүгийн бүтээгдэхүүн уг “философид” үндэслэсэн. Казакстан, Индонез, Катар, Малайз, Сингапур гээд

18 орон энэ бүтээгдэхүүнийг гаргадаг бөгөөд 2014 оны эцэст 294 тэрбум ам.долларын өрийн үлдэгдэлтэй байжээ.

Үндсэндээ дээрхийн адил асуудлаас зайлсхийх туршлага Монголд ч бий ажээ. Тухайлбал Иргэний хуулийн шинэчилсэн найруулга батлагдахаас өмнө иргэд хооронд хүүтэй мөнгө зээлэх эрх зүй бүрдээгүй байжээ. Тухайн үед хүүг үндсэн зээлийн дүн дээр нэмсэн байдлаар гэрээнд хуурамчаар бичдэг байсан аж. Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Амарсайханы хувьд “Нэгэнт амьдралд бий болсон харилцааг зөв олж харж, хуульд зөв зохицуулах нь чухал” гэж үздэг байна. Арга бүхэн амьдралд хэрэгжих боломжтой биш аж.



Харин хуульд орсон нэмэлт заалтын тухай арай өөр тайлбарыг “Де Юре Партнерс” хууль зүйн фирмийн өмгөөлөгч С.Багбаяр өгсөн юм. Түүний хэлснээр хариу төлбөр гэснийг шууд хүү гэж ойлгох нь буруу. Учир нь тус хуулийн 282 дугаар зүйл нь “Зээлийн гэрээний хүү”-ний тухай тусгайлан зохицуулж өгсөн байдаг. Энэ зүйлийн нэгд “Зээлийн гэрээгээр талууд хэлэлцэн тохиролцож хүү тогтоож болно” гэж заасан бөгөөд дээрх нэмэлт орсноор энэхүү заалтад өөрчлөлт ороогүй байна. С.Багбаяр “хуульд хүү гэдэг нэр томъёог ашиглаж байгаа бол түүнийг

өөр үгээр орлуулан ашигладаггүй” гэсэн юм. Харин дээр дурдсан Улсын дээд шүүхийн тайлбар нь Иргэний хуулийн 44, 45, 46 дугаар бүлэгт хамаарах юм. Эдгээр бүлэгт банк болон бусад хадгаламж зээлийн үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллагын иргэнтэй харилцах харилцааг зохицуулдаг. Тиймээс иргэд хоорондын зээлийн харилцаанд хариу төлбөр гэдгийг хүүгээс бусад хэлбэрээр төлбөр тооцоо авах гэж ойлгоно гэдэг тайлбарыг тэрбээр өгсөн юм.

Өнөөдөр иргэдэд гэрээ байгуулж мөнгө хүүлэх “бизнес” нэлээд газар авсан. Тэгэхдээ хүүгээс гадна богино хугацаанд зээл олгосны шимтгэл авах, алданги тооцох, зарим тохиолдолд эд хөрөнгийг хураан авах эрхийг зээлдүүлэгч гэрээндээ тусгадаг аж. Энэ нь ч одоогийн зохицуулалтаар нээлттэй юм. Хэдэн жилийн өмнөх нэгэн тохиолдлыг санаж байна. Нэг иргэн зээлүүлсэн мөнгөө олж авч чадахгүй болжээ. Зээлсэн этгээд нь утас, хаягаа сольж түүнтэй уулзалгүй зугтах болсон тул “Мөрдөгч Деррик” нэвтрүүлгийн багт хандсан байна. Тэдний “мөрдлөг” амжилттай болж хоёр талыг уулзуулдаг. Гэтэл авсан зээлээ төлж чадахгүй нь гэсэн хариу сонссон зээлдүүлэгч иргэн зээлсэн этгээдийн автомашиныг авч явдаг юм (авсан зээлээ эргүүлэн төлбөл буцаах нөхцөлтэйгөөр).

Түүнчлэн иргэдийн зээлийн гэрээ нь ихэнх тохиолдолд богино хугацаатай, зах зээлийн дунджаас хэт өндөр хүүтэй байдаг. Ялангуяа томоохон худалдааны газрууд, захуудын наймаачдад хүүг өдрөөр нь тооцдог гэнэ. Үүний улмаас зээлээ төлж чадалгүй хугацаа хоцроход хүүгийн төлбөр нь үндсэн зээлээсээ давж иргэн хохирох нь элбэг тохиолдох болж. Гэхдээ энэ нь иргэд хуулийн мэдлэггүйтэй холбоотой. Иргэний хуулийн 282 дугаар зүйлийн хоёр дахь заалт энэ асуудлыг тодорхой зохицуулж өгчээ. Хэрэв зээлийн хүүг хэт өндөр байна гэж үзвэл шүүхэд гомдол гаргаж болно. Шүүх хүүгийн хэмжээг зээлдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд илт хохиролтойгоор тогтоогдсон гэж үзвэл зээлийн хүүг багасгаж болдог юм байна.

Мөнгө хүүлэгчид эцэстээ зээлдэгчийг айлган дарамталж, танхайрах, сүрдүүлэх зэрэг гэмт хэргийн шинжтэй болсоор байгаа юм. Иргэн хоорондын зээл гэдэг энгийн харилцааны хоёр туйлд далд эдийн засаг, шударга бус мөлжлөг болон зах зээлийн хэрэгцээ бодитойгоор эсрэгцэн оршино. ■



Фотог Б.Индраа

Аялал жуулчлал

Мальдив “мандсан” ITB Berlin 2016-гийн өдрүүд

Б.ЭНХ

Жил бүр 187 орны 100 мянга гаруй хүн зорин ирдэг И Тэ Бэ /ITB Berlin/ аялал жуулчлалын хамгийн том үзэсгэлэнг энэ жил 50 дахь удаагаа зохион байгууллаа. Энэ жил нийт 10 мянган аж ахуйн нэгж, хувь хүн өөрсдийн бүтээгдэхүүнээ сурталчлахаар Берлин хотноо ирсэн. Жил бүр нэг орон онцлох улсаар оролцдог ба түрүү жил Монгол Улс байсан бол энэ удаа Мальдив өөрсдийгөө давуу эрхтэйгээр сурталчилж, тугаа мандууллаа

Өнгөрсөн жил И Тэ Бэгийн 160 мянган ам.метр бүхий 26 танхимд нийт 175 мянган хүн орж, гарсан гэх баримтыг тус үзэсгэлэнгийн судалгааны хэсгээс мэдээлсэн байдаг. Үүний гуравны хоёр нь буюу дийлэнх нь гаднаас тус үзэсгэлэнг зорьж ирсэн зочид байжээ. Үзэсгэлэнд ирсэн зочид нэг өдөрт 17 км алхдаг байна. Товчхондоо, И Тэ Бэ бол бүх дэлхийгээр нэг дор зочлох боломж. Өөрсдийнхөө бүтээгдэхүүнийг сурталчлахаар ирсэн оролцогчид өөрийн орны өнгө төрхийг харуулсан өвөрмөц тохижилтоор

оролцогчдын нүдийг хужирлаж, ороод гарахыг уриалдаг. Мөн үзэсгэлэнд оролцогчид олон улс даяар хамтарч ажилладаг түншүүдтэйгээ уулзаж, шинэ түнштэй болохоор ирдэг.

Монгол Улс 2015 онд түнш орон байсан учир нэлээд өнөр бүрэлдэхүүнээр оролцож, өргөн хүрээнд үйл ажиллагаанууд зохион байгуулж байсан. Тус үзэсгэлэнд манай улс 1989 оноос эхлэн оролцсон бол Улаанбаатар хотыг бие даасан аялал жуулчлалын зорих газар болгон таниулах ажил хоёр дахь жилдээ хийгдэж байна. Өнгөрсөн жил 16 компани оролцож байсан бол энэ жил хувь, хувьсгалын нийлээд найман байгууллага оролцлоо. Энэ удаа манай улс 100 ам.метр талбайг тохижуулжээ. Манай улсаас БОНХАЖ-ын сайд Н.Батцэрэг салбараа төлөөлөн оролцож Монголын талбайг нээж үг хэллээ. Тэрбээр энэ үеэр УИХ-ын хаврын чуулганаар аялал жуулчлалын хуулийн шинэчилсэн хувилбарыг хэлэлцүүлж батлуулна гэдгийг хэлсэн билээ. Мөн ирэх аравдугаар сард Монголд зохион байгуулагдах “Silk Road” олон улсын

хуралд Мэссе Берлин группын даргыг урьсан нь содон байв. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Нийслэлийн аялал жуулчлалын газар, Монголын аялал жуулчлалын холбоо, МИАТ ХК, туроператор зургаан компани, үндэсний урлагийн хамтлаг гэсэн бүрэлдэхүүнтэйгээр зургаа хоногийн турш улс, хотын аяллын мэдээлэл өгч, сурталчилгаа явуулж ажиллаад ирсэн юм.

И Тэ Бэ үзэсгэлэнгийн үндсэн арга хэмжээ энэ сарын 9-нд албан ёсоор эхэлсэн бөгөөд Мальдив улс нээлтийн тоглолтыг хийлээ. Үзэсгэлэн 13-ныг хүртэл дөрвөн өдөр үргэлжилсэн. Мальдив тус үзэсгэлэнд өөрсдийгөө тогтвортой аялал жуулчлалын тод жишээ болон хөгжинө хэмээн танилцуулж байлаа. Аяллын салбарт технологийн дэвшлийг нэвтрүүлэх үйл ажиллагааг улам хөхиүлэх үүднээс энэ жилийн И Тэ Бэ “Аялал 4.0” гэх ойлголтод анхаарлаа хандуулж байна. Үүний тод жишээ нь үзэсгэлэнгийн урд талын үүдэнд байрлуулсан Тошиба компанийн хүн төст робот юм. Тус робот нь зочдод үзэсгэлэнгийн талаар мэдээлэл өгөх, утгах үүрэгтэй хүлээн авах ажилтан юм. Мөн “И Тэ Бэ Хятад” хэмээх үзэсгэлэнг зохион байгуулахаар болсноо энэ жил албан ёсоор зарласан нь Хятадын зах зээлд ямар их ач холбогдол өгч буйг мөн харуулж байна. Тус үзэсгэлэнгийнхний зүгээс энэ удаад ч Соёлын аялал, ЛГБТ (Лесби, Гей, Бисекс, Трансгендер) аялал гэх сэдэвчилсэн аяллын бүтээгдэхүүнүүдэд түлхүү анхаарч, сурталчилсан билээ. ▶



► Мальдив: Далайн гялтганасан цагаан элст эргүүд, оюу ногоон өнгийн далайн тасархай хэсгүүд, тэнгисийн гүн рүү шумбах өвөрмөц орчныг санал болгодог энэ улсыг газрын диваажин гэж нэрлэдэг. Энэтхэгийн далайд орших арлын энэ улс И Тэ Бэ үзэсгэлэнд 1984 оноос хойш оролцож байгаа бөгөөд байгальд ээлтэй, хяналт зохицуулалт өндөртэй аялал жуулчлалын хөгжлийн загвар болж буй орон. Мальдив ойролцоогоор 1190 шүрэн арал болон 26 гинжин арлуудаас тогтсон, Азийн хамгийн жижиг улсуудын нэг. Тус улсын цаг агаар 23-31 хэмийн хооронд хэлбэлзэх халуун орны уур амьсгалтай. Мальдив улсын албан ёсны хэл Дивехи хэдий ч 1960 онд боловсролын тогтолцоондоо Англи хэлийг багтаасан учир өдгөө иргэд нь англиар чөлөөтэй харилцдаг. Эдийн засгийн гол салбарууд нь загас агнуур мөн сүүлийн үед аялал жуулчлал нэлээд хүчээ авч буй. Хүнсний гол үндсэн бүтээгдэхүүнүүд нь далайн гаралтай хүнс тэр дундаа туна загас, наргил жимс, цагаан будаа. Мальдив аялал жуулчлалаа хөгжүүлэх үүднээс олон улсын онгоцны буудлаа өргөтгөж, хойд, урд хэсэгтээ зочид буудал, амралтын газруудыг нэмж барьж байгаа. Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд маш их зүтгэл гаргадаг тус улс сэргээгдэх эрчим хүчийг түлхүү олборлон хэрэглэдэг.

Мэссе Берлиний гаргасан статистик мэдээллээс үзэхэд тус үзэсгэлэнгийн үеэр хийгдсэн нийт борлуулалт өнгөрсөн жилийнхээс өсч, 6.7 тэрбум еврод хүрчээ. Мэссе Берлин хэмээх групп



/И Тэ Бэ үзэсгэлэнгийн 2016 оны түнш орон Мальдивийн үзэсгэлэнгийн танхим дахь сурталчилгааны талбай Зураг 1/



И Тэ Бэ аялал жуулчлалын үзэсгэлэнгийн 26-р танхим дахь Монголын сурталчилгааны талбай /Фотог Д.Наранцэцэг/ 2016.03.09

дор байдаг компаниудын нийт жилийн орлого 238 сая еврод хүрсэн нь 2013 оныхоос 27 хувиар өссөн үзүүлэлт аж. Өнгөрсөн жил Мэссе Берлиний зохион байгуулсан 102 арга хэмжээнд хоёр сая гаруй хүн оролцжээ. Энэ жил зохион байгуулах томоохон арга хэмжээнүүд гэвэл Олон улсын ногоон долоо хоног /1.15-24/, Жимсний Ложистик /2.3-5/, И Тэ Бэ Берлин /3.9-13/, Олон улсын үйлдвэрлэгч, жижиглэнгээр бараа худалдаалагчдын IFE /9.2-7/. Мэссе Берлин нь үзэсгэлэн, хурал зохион байгуулдаг дэлхийн ТОП 10 компанийн нэг гэгддэг. 1966 оноос хойш зохион байгуулж буй И Тэ Бэ дэлхийн хамгийн том аялал жуулчлалын үзэсгэлэнгийн хувьд энэ жил 50 жилийн ойгоо тэмдэглэж байна.

Берлин хотын саалийн үнээ

Берлиний эдийн засгийн бүтэц нэлээд сайн төрөлжсөн бөгөөд олон жилийн түүхт үйлдвэрлэгчид, хүчтэй жижиг дунд үйлдвэрлэл, эрчтэй үйлчилгээний салбар мөн инноваци сайтай өндөр технологи бүхий бизнесүүдээр тодорхойлогддог. Тэр дундаа аялал жуулчлалын салбар нь тус хотын аль ч бизнесүүдээс илүү өндөр өсөлтийг үзүүлдэг. Гаднын иргэдийн тус хотод үдэллээд буцах орхоногийн тоо жил бүр өмнөх рекордоо эвддэг ба өнгөрсөн онд л гэхэд 28.7 саяд хүрснийг Берлиний Статистикийн газраас мэдээлж байв.

Берлин нь Европтоо хүмүүсийн хамгийн их зочилдог ТОП гурван хотын нэг бөгөөд аялахаас илүүтэй бизнесийн зорилгоор ирж буй гаднынхан дийлэнх болдог онцлогтой. Тодруулбал, Берлин дэлхий даяарх хурал чуулган, үзэсгэлэнгийн зах зээлд гол тоглогчдын нэг. Аялал жуулчлал,

уулзалтууд нь Берлиний эдийн засгийн оргил нь бөгөөд энэ үеэр бий болдог түр ажлын байр л гэхэд хэдэн зуун мянгаар тоологддог.

2014 онд Берлин хотноо зохиогдсон 131 мянган арга хэмжээнд оролцох зорилгоор нийт 11 сая хүн ирсэн нь өмнөх жилээсээ гурван хувиар өссөн үзүүлэлт байжээ. Берлиний зочид буудлуудын гуравны нэг нь тэр олон хурал чуулганаас үүдэн бий болж, тэдний хүчинд оршин тогтнож буй. Хурал чуулганы зах зээл нь өдгөө зочид буудлуудын төдийгүй Берлиний эдийн засгийн гол тулгуур багануудын нэг болоод байгаа юм.

“VisitBerlin”-ий захирал Бурхард Кикер “Нэг өдөрт болдог дунджаар 360 арга хэмжээ нь 30 мянган оролцогчыг хамардаг Берлин хотын энэ зах дээрх байр суурийг тод илтгэнэ” хэмээсэн байдаг.

Берлин нь хотын аялал жуулчлалын хувьд хамгийн өндөр үзүүлэлттэй хотуудын нэг. Томоохон арга хэмжээг хотдоо зохион байгуулах бүрт аялал жуулчлалын салбар нь илт өндөр өсөлт үзүүлдэг. Тухайлбал UEFA-ын Европын хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн Берлинд өнгөрсөн жил болсон бөгөөд энэ үеэр нийт 5.8 сая хүн ирж 13.8 сая өдрийг өнгөрүүлжээ. Үүний дүнд 2015 оны эхний хагаст гаднын гийчдийн тоо өмнөх оны мөн үетэй нь харьцуулбал 8.5 хувиар өссөн аж. Аялал жуулчлалын өндөр өсөлттэй уялдуулан тус улсад дэлгүүр хэсч бараа бүтээгдэхүүн худалдан авах нь ч нэмэгдэж дэлгүүрүүд эгнэсэн гудамжууд хүрээгээ тэлсээр. Хүн амын тоо болон аялал жуулчлалд гарч буй тэсрэлтэт өсөлт нь 200 мянган хүнийг шинээр ажлын байртай болоход тусалж буй. ■

Онол

Улс төрийн соёл

Төгсгөл, түрүүч нь өмнөх дугаарт

С.ЗУЛЬФИКАР

(Удирдлагын академийн улс төр судлал, нийгмийн удирдлагын тэнхимийн эрхлэгч доктор, дэд профессор)

Улс төрийн соёлын талаарх анхны цэгцтэй өргөн хүрээтэй, харьцуулсан судалгааг Габриел Алмонд, Сидней Верба нар хийсэн. Габриел Алмонд Герман дахь улс төрийн соёл сэдэвт өгүүлэлдээ өнөөг хүртэл улс төрийн соёлын тухай асуудал онол, арга зүйн агуулга бүхий 40 гаруй ном, 50 гаруй өгүүлэл бичигдэж, судалгааны 1000 гаран бүтээлд дурдагдсан (Gabriel Almond, 1993) болохыг тэмдэглэжээ. Хоёр судлаач маань АНУ, ХБНГУ, Их Британи, Итали, Мексик улсуудыг харьцуулан, улс төрийн соёлын ялгаатай болон нийтлэг байдалд нь дүн шинжилгээ хийжээ. Чингэхдээ улс тус бүрээс 1000 хүнээс тухайн нийгмийн адилсалыг буюу иргэний соёлын хэв шинжийг тодорхойлох анкетын судалгаа авчээ. Судалгааны явцад цуглуулсан өгөгдөл нь иргэдийн улс төрийн институудыг ойлгох, төсөөлөх, хандах байдал, тэдэнд бий болсон үнэлэмжийг тодорхойлсон. Тэдний судалгааны үр дүн эдгээр улсуудад улс төрийн соёлын гурван нийтлэг шинж чанар буюу идеал загвар байгааг харуулсан. Тэрхүү гурван идеал загварыг хязгаарлагдмал (parochial), субъектын (subject), оролцооны (participatory) улс төрийн соёл гэж ангилсан (хүснэгт 1-ийг үзнэ үү).

Улс төрийн соёлын дээрх гурван хэлбэр нь тухайн улсын улс төрийн тогтолцоо, улс төрийн орц (хүсэл сонирхол)-ыг тодорхойлох байдал,

тэрхүү орцыг гарц болгож байгаа улс төрийн шийдвэр, үйл ажилагааны талаарх иргэдийн ойлголт, хандлага болон улс төрийн үйл явц дахь тэдний оролцооны түвшинээр тодорхойлогдоно. Нийгмийн гишүүдэд улс төрийн тогтолцоо, улс төрийн орц, гарцын талаар тогтсон хандлага байхгүй бөгөөд улс төрийн идэвхгүй төлөвийг улс төрийн соёлын хязгаарлагдмал загвар гэж үзэх бөгөөд иргэдийн улс төрийн талаарх ойлголт, төсөөлөл, хандлага маш сул, идэвхгүй байдаг. Улс төрийн соёлын субъектын загварт иргэд улс төрийн тогтолцооны талаар тодорхой ойлголт төсөөлөлтэй байх боловч улс төрийн орцыг тодорхойлох харилцаан дахь оролцоо нь сул, идэвхгүй байна. Харин улс төрийн шийдвэр, үйл ажиллагаа нь нийгмийн харилцаа болон хувь хүмүүст нөлөөлөх шинж чанартай гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Өөрөөр хэлбэл улс төрийн аливаа шийдвэрийн үр дүн, үр нөлөөнд ач холбогдол өгч харин орцод төдийлэн анхаарал хандуулдаггүй байна. Түүнчлэн хувь хүмүүсийн улс төрийн оролцоо харьцангуй сул байдаг. Улс төрийн соёлын оролцооны загварт иргэдийн дунд улс төрийн тогтолцооны талаар, улс төрийн үйл явц дахь орц, гарцын талаар тодорхой ойлголт, төсөөлөл, хандлага бий болгосон байх бөгөөд тэр хэрээр улс төрийн оролцоо нь өндөр байдаг. Тухайн улсын болон нийгмийн гишүүдийн дунд дан ганц төрлийн улс төрийн соёл бий болж, төлөвшихгүй ч байж болно. Учир нь нийгмийн гишүүд, бүлгүүдийн ялгаатай байдлыг шалгуур болгох аваас дээрх гурван загварын холимог хэлбэрийн улс төрийн соёл бүрэлдэх магадлал бий.

Удирдлагын академид төрийн удирдлагаар мэргэшүүлэх дипломын сургалтанд хамрагдаж байгаа суралцагчдад “Улс төрийн соёл” хичээл орох явцдаа дээрх улс төрийн соёлын гурван идеал загвар хэрхэн илэрч байгааг тандах зорилгоор (улс төрийн ойлголт, хандлага, оролцоог тодорхойлох) асуулт тавьж, гурван сонголттой хариулт өгүүлсэн. Судалгаанд нийт 63 суралцагч хамрагдсан бөгөөд хариултын гурван хувилбараас өөрт тохирох сонголт хийсэн. Судалгаанд хамрагдсан хүмүүс дараах байдлаар хариулсан. Үүнд:

- Улс төр миний амьдралд огт нөлөөгүй. Надад улс төрийн талаар ямар нэг ойлголт байхгүй бөгөөд өөрөө ч сонирхож оролцож байгаагүй гэж 4.7 хувь нь;

- Улс төрийн шийдвэр бидний амьдралд зарим талаар нөлөөлж байдаг. Шаардлагатай тохиолдолд улс төрийн үйл ажиллагаанд оролцдог гэж 71.2 хувь нь;

- Хүмүүсийг улс төрөөс ангид ойлгох аргагүй. Би улс төрийн үйл явц, үйл ажиллагааг байнга сонирхож, идэвхтэй оролцож байдаг гэж 24 хувь нь тус тус хариулсан.

Дээрх гурван хариултын хувилбар нь улс төрийн соёлын хязгаарлагдмал, субъектын болон оролцогч хэв шинжийн аль нь тухайн хүнд илэрч байгааг тодорхойлох бөгөөд судалгаанд хамрагдсан суралцагчдын 71.2 хувь улс төрийн тогтолцооны талаар тодорхой ойлголттой, улс төрийн шийдвэрийг зөв эсхүл буруу гэж үнэлэх хандлагатай байж, шаардлагатай тохиолдолд улс төрийн үйл явцад ямар нэг байдлаар оролцдог боловч улс төрийн орцод тэр бүр ач холбогдол өгдөггүй байна. Тэдний хувьд субъектын загвар бүхий улс төрийн соёлтой гэж тодорхойлж болно. Өөрөөр хэлбэл шаардлагатай гэж үзсэн нөхцөлд улс төрийн үйл явцыг сонирхож байгаа нь ямартай ч улс төрөөс ангид хүмүүс биш болохыг илтгэж байгаа хэрэг. Үүнд үндэслэн дээд боловсролтой, дунд насны Монгол хүмүүсийн дунд улс

Хүснэгт 1. Улс төрийн соёлын хэлбэр илрэх байдал

Улс төрийн соёлын загвар	Улс төрийн тогтолцоо	Орц (хүсэл сонирхол)	Гарц (бодлого, шийдвэр)	Хувь хүний хувьд оролцоо
Хязгаарлагдмал (Parochial)	0	0	0	0
Субъектын (Subject)	1	0	1	1
Оролцооны (Participatory)	1	1	1	1

▶ төрийн субъектын соёл давамгайлах хандлагатай байна гэсэн ерөнхий дүгнэлт хийлээ. Энгийнээр бол дээд боловсролтой, дунд насны Монгол хүмүүс шаардлагатай үедээ улс төрийн идэвхтэй субъект байхыг илүүд үздэг байж болохоор байна. Түүнчлэн судалгаанд хамрагдсан суралцагчдын 24% улс төрийн үйл ажиллагааг байнга сонихрож идэвхтэй оролцож байдаг гэж хариулжээ. Судалгаанд хамрагдсан дөрвөн хүн тутмын нэг нь улс төрийн хувьд маш идэвхтэй иргэд байна. Иймд дундаж насны, дээд боловсролтой Монгол хүмүүсийн 24 хувь нь оролцогч загвар бүхий улс төрийн соёлтой гэсэн

төрийн тогтолцоог тухайн улсад тохирч байна, тохирохгүй байна, улс төрийн бодлого болгохоор дэвшүүлж байгаа асуудал нь зөв эсхүл буруу, улс төрийн шийдвэр нь алдаатай эсхүл зөв гэх мэтээр үнэлж дүгнэж болно. Хамгийн гол нь тодорхой ойлголт, хандлага байгаа эсэх нь улс төрийн соёлын ямар загвар давамгайлж байгаа эсхүл илэрч байгааг тодорхойлох шинжтэй. Би хувьдаа соёлын талаар өмнө нь тэмдэглэсэн тайлбаруудаас “Соёл бол боловсон харилцаа, харилцааны зөв хандлагатай байх” тухай ойлголт Монгол хүмүүст давамгайлдаг гэж боддог. Учир нь бидэнд улс төрчдийг

сөрөгөөр үнэлэж байгаагаас, УИХ-ын гаргасан шийдвэр надад хамаатай, хамаагүй эс бөгөөс зөв буруу гэж бодож байгаагаас үл хамааран бий болж, илэрч байдаг. Иймд улс төрийн соёлыг дан ганц эерэг шинж чанартай улс төрийн үзэгдэл, үйл явц, үнэлэмж, үнэт зүйл гэж явцуу хүрээнд ойлгож болохгүй. Сөрөг шинж чанартай улс төрийн үйл явц, цаашлаад хандлага байх аваас үүнийг ердөө л улс төрийн соёлын нэг хэлбэр, илэрч байгаа хэв шинж гэж ойлгох нь зүйтэй. Хавар болохтой зэрэгцэн улс төрийн жагсаал, цуглаан болох нь ихсэж хэвлэл мэдээлэл, нийгэм тэр аяараа улс төрөөр амьсгалж байдаг. Үүнийг заримдаа хаврын синдром буюу хаврын сэтгэл хөөрөл гэж нэрийдэх нь бий. Гэтэл юу гэж нэрлэхээс үл шалтгаалан тухайн тохиолдолд өөрийн онцлогтой улс төрийн соёл бүхий үзэгдэл, үйл явц бий болж байгаа юм. Товчхондоо улс төрийн соёл нь эерэг, сөрөг шинж чанар бүхий ойлголт, хандлага, төсөөлөл, үйл явцын аль алинийг өөртөө агуулна.

Улс төрийн соёл хувь хүн, нийгмийн зан үйлтэй холбоотой юу? гэсэн асуулыг судлаачид байнга тавьсаар иржээ. Ялангуяа нийгмийн зан үйл нь улс төрийн соёл ялгаатай илрэх, төлөвших нөхцөл болох уу? Ричард Фаген, Роберт Такер, Стевен Вайт нар социалист системтэй улсуудад хийсэн судалгааны үр дүнд тулгуурлан улс төрийн соёлыг зан үйлийн онцлогтой шууд холбож ойлгох нь өрөөсгөл гэж үзсэн бөгөөд харин улс төрийн тодорхой соёлыг нийгэмд хүлээн зөвшөөрүүлэх замаар нийгмийн зан үйлд нөлөөлөх туршлага байгааг тэмдэглэжээ (Robert Tucker, 1972). Өөрөөр хэлбэл социалист системтэй улсуудад улс төрийн нэг үзэл суртал давамгайлж, түүнтэй уялдсан улс төрийн тогтолцоо, харилцаа хүлээн зөвшөөрөгдсөн байдаг бөгөөд тодорхой хугацаа өнгөрсний дараа нийгмийн гишүүдэд нийтлэг зан үйл хэвшдэг (Stephen White, 1979).

Миний санаанаас гардаггүй нэг тохиолдол үүнийг зөвтгөөд байх шиг. 2003 онд Унгарын Будапешт хот дахь Төв Европын их сургуульд Нээлттэй нийгэм хүрээлэнгийн зохион байгуулсан судалгааны арга зүйн семинарт хамрагдаж билээ. Тэрхүү семинарт хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүн байсан улсууд болон Зүүн Европын социалист блокын улсуудын их, дээд сургуулийн багш, судлаачид ▶



ерөнхий дүгнэлт хийж болно. Бүхэлд нь аваад үзвэл энэ төрлийн нийгмийн сегментэд улс төрийн субъектын болон оролцогчийн соёл давамгайлж байгаа болно. Харин судалгаанд хамрагдсан суралцагчдын 4.7 хувь нь улс төрийн талаар ямар нэгэн ойлголтгүй хийгээд улс төр тэдний болон нийгмийн амьдралд ямарваа нөлөөгүй гэж хариулсан нь хязгаарлагдмал загварын улс төрийн соёлтой болохыг харуулж байна. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн дунд субъект-оролцооны загварын шинж чанар давамгайлсан улс төрийн соёл түлхүү илэрч байгаа нь сонирхол татаж байна.

Улс төрийн соёлын аль ч загварт улс төрийн тогтолцоо, орц, гарцын талаарх ойлголт, хандлага нь эерэг болон сөрөг шинжтэй байж болно. Тухайлбал, улс

ёс зүй, ёс суртахууны өндөр шалгуурыг хангасан хүмүүс байх тухай төсөөлөл давамгайлж, түүнтэй уялдсан хүлээлт бий болсон байдаг. Хэрэв улс төрчид ёс зүйн алдаа гаргавал түүнийг улс төрийн соёлгүй нэгэн гэж үнэлэх нь бий. УИХ-ын чуулганы хуралдааны явцад гишүүд бие биенээ элдвээр хэлэх, дайрах үзэгдлийг улс төрийн соёлгүй байдал буюу боловсон харилцаанд суралцаагүй гэж үздэг нийтлэг хандлага байгаагаас үүдэн улс төрийн соёл бол эерэг шинж чанартай байх учиртай гэсэн төсөөлөл нийгмийн харилцаанд давамгайлдаг гэсэн дүгнэлтэд хүргэнэ.

Хэдий тийм боловч арга зүй талаас нь, мөн өргөн хүрээнд тайлбарлах аваас улс төрийн соёлын аливаа хэлбэр Монгол улсын иргэд улс төрийн намуудын үйл ажиллагааг эерэг эсхүл

► хамрагдсан юм. Хачирхалтай нь семинарт хамрагдсан багш, судлаачид хэдийгээр эрдэм судлалын туршлага, насны хувьд харилцан адилгүй хүмүүс боловч өөр хоорондоо ямарваа бэрхшээлгүй ойлголцож, харилцан санал солилцож байсны дээр олон зүйл дээр нийтлэг төсөөлөл, ойлголт, хандлагатай байсныг тод санаж байна. Семинар болоогүй үед өөр өөрийн улсад өрнөж байгаа улс төр, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлийн талаар хөөрөлдөн, дор бүрнээ үнэлэлт дүгнэлт өгч, санал бодлоо хуваалцаж байв. Ярьж байгаа хийгээд асуудлыг үнэлж дүгнэж байгаа нь хүртэл бараг ижил байж билээ. Яг энэ үед ОХУ-ын Дагестанаас ирсэн профессор (нэрийн санахгүй байна) бид чинь ер нь бол бүгд зөвлөлтийн хүмүүс шүү дээ гэдэг байгаа. ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улсуудаас ирсэн хүмүүсийн тухайд яах аргагүй зөвлөлтийн хүмүүсийн шинж чанартай байх нь эргэлзээгүй. Харин миний болон Зүүн Европын орнуудын судлаачдын тухайд улс орон нь ЗХУ-ын улс төрийн нөлөөнд байсны хувьд адилтгаж болох олон үнэт зүйлээр холбогдсон байх талтай. Ямартай ч тэрээр барууны их, тэдэд сургуулийн багш, судлаачдаас бидний ялгааг харин өөр хороондоо ижил байгааг ийнхүү тайлбарласан шиг санагддаг юм. Үндсэндээ улс төрийн ижил үзэл суртал нийгмийн бүхий л хүрээний харилцааг тодорхойлж, зохицуулж ирсэн 40-70 жилийн хугацаанд хүмүүст ижил төстэй үнэт зүйл, үнэлэмж, зан үйл, адилсал аяндаа төлөвшсөн байх л даа. Нийгэм- улс төрийн байгуулал нь ижил байсан нь бидэнд нийтлэг соёл бий болгосон болохыг тэрбээр хэлээд байж л дээ. Түүнээс хойш 14 жил өнгөрсөн тул бидний хооронд тэрхүү ижил төстэй байдал хадгалагдсаар байгаа эсхүл бүдгэрч алга болсон эсэхийг хэлж мэдэхгүй байна. Ямартай ч нийгэм-улс төрийн ижил төстэй байгуулал нь улс төрийн ижил төстэй соёл бий болгож улмаар нийтлэг зан үйл бүрэлдэхэд нөлөөлжээ.

ИХ Британий судлаач Филип Даниел Консерватив намын улс төрийн үйл ажиллагааг судалсаны үндсэн дээр 80-аад онд тухайн үеийн ерөнхий сайд асан Тичерийн засгийн газрын явуулсан өмч хувьчлал, улсын салбарын шинэ удирдлага, төр-хувийн хэвшлийн түншлэл гэх мэт улс төрийн бодлого, үйл ажиллагаа нь Британий

иргэдийн дунд шинэ үнэт зүйл, хандлага угтаа бол нийгмийн зан үйл бий болгосныг тогтоожээ. Британид Консерватив намын хэрэгжүүлсэн улс төрийн бодлого, үйл ажиллагаа нь иргэдийн дунд өмчтэй болох, аливаа зүйлийн үр ашиг, үр нөлөөг зөв тооцох улс төр-нийгмийн шинэ сэдэл, зан төлөв бүрдүүлсэн байна. Үүний нэгэн адил өнгөрсөн 25 жилийн туршид Монголын улс төрд улс төр-эдийн засаг-нийгмийн либералчилал явагдаж, түүний үр нөлөөгөөр улс төрийн шинэ харилцаанууд төлөвшсөн гэдгийг бид бэлхэнээ мэдэж байгаа. Улс төрийн шинэ харилцаа нь мөн адил шинэ зохион байгуулалт, институцчилалыг араасаа дагуулсан. Энэ явцад сайн муу, зөв буруу, алдаа оноо аль аль нь байсан. Тэрхүү шинэ институцчилалыг улс төрийн байгууллага, иргэд нийтлэг байдлаар хүлээн авч улс төрийн адилсал бүхий соёлтой болж чадахын зэрэгцээ өөр өөрийн онцлогоос шалтгаалж улс төрийн ялгаатай соёлыг бий болгосон байх талтай.

Манай улс төрийн томоохон хоёр намын тухайд байгууллагын соёл, угтаа бол улс төрийн соёл нь ялгаатай болохыг судлаачид тэмдэглэдэг. Тийм байдал олон тохиолдолд тодорхой ажиглагддаг. Тухайлбал, хоёр намын хурлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж байгааг үзэж суухад Арчдилсан Намын хурал халуухан, заримдаа юу л болдог болдоо гэж бодоход хүргэсэн хэлбэрээр зохион байгуулагддаг бол Монгол Ардын Намын хурал тогтсон дэг жаягтай, сахилга баттай, магадгүй уйтгартай юм шиг зохион байгуулагдаж байдаг. Хурлын зохион байгуулалтын хувьд тэр нь зөв энэ нь буруу гэх аргагүй юм. Ердөө л тухайн хоёр намд ялгаатай улс төрийн соёл төлөвшсөн байгааг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй. Ардчилсан нам дотоод ардчилал сайтай боловч зохион байгуулалтын институцлал нь сул байдаг. Үүний шалтгааныг олон намын нэгдэл бүхий улс төрийн хүчин гэдэгтэй нь холбож ойлгох нь зүйтэй. Харин Ардын нам дотоод ардчилал нь харьцангуй сул мэт боловч зохион байгуулалтын институцчилал сайтай байдаг. Үүний шалтгааныг 90 гаран жилийн түүхтэй улс төрийн нам гэдгээр ойлгож болно. Ямартай ч аль алинд нь ялгаатай улс төрийн соёл төлөвшсөн байна.

Эрхэм уншигч та улс төрийн


соёлыг арга зүйн талаас нь тайлбарлан тодорхойлсон судлаачдын байр суурь болон өгүүлэл бичигчийн эмпирик тайлбараар дамжуулж тус ойлголтын талаар тодорхой төсөөлөлтэй болж чадсан байх гэж найдаж байна. Мэдээд байгаа атлаа илэрхий тодорхойлж чадахгүй байсан ойлголт маань улс төрийн харилцаанд төдийгүй нийгмийн амьдралд тодорхойлох, нөлөөлөх шинжтэй үзэгдэл, үйл явцын агуулж байгааг судлаачдын байр суурь илтгэж байна.

Улс төрийн соёлыг хувь хүний, нийгмийн бүлгийн, тухайн улс үндэстний хувьд улс төрийн тогтолцоо, түүний бүрдэл болж байгаа институт, субъект, үзэгдэл, үйл явцын талаарх ойлголт, мэдлэг, төсөөлөл, үнэлэмж, хандлага гэж нэгтгэн дүгнэх байна. Улс төрийн соёл нь тухайн хувь хүн, нийгмийн бүлэг, улс үндэстний зохион байгуулалт, нийтлэг үнэт зүйл, онцлог, хүлээн зөвшөөрөгдсөн үзэл суртал, улс төрийн орчноос үүдэн ялгаатай эсхүл ижил төстэй байж болохын дээр цаг хугацааны өөрчлөлттэй уялдан шинэчлэгдэх шинж чанартай. Эмпирик судалгааны үр дүн нийгмийн харилцаанд бий болсон улс төрийн соёл нь нийгмийн нийтлэг зан үйлд нөлөөлж, түүнийг тодорхойлох шинж чанартай байж болохыг дэлгэн харууллаа.

Гагцхүү улс төр судлалын бусад судлагдахуунтай харьцуулахад улс төрийн соёлын талаарх тухайлсан судалгаа харьцангуй цөөн, ялангуяа Монголын нийгэмд бий болсон улс төрийн соёлыг судалсан онолын болон эмпирик судалгааны үр дүн хангалтгүй байгаа юм. Харин улс төрийн үзэгдэл, үйл явцыг тайлбарлах үл хамаарах болон хамаарах хувьсагч болох талаас нь авч үзвэл улс төрийн соёл нь аливаа зүй тогтолд дүн шинжилгээ хийх, тайлбарлах, цаашлаад учир шалтгааны зүй тогтолд нь тулгуурлан шийдэл хайх арга хэрэгсэл байж болохоор байна. Иймд нийгмийн улс төрийн хүрээнд бий болсон аливаа үзэгдэл, үйл явцад тухайлсан үнэлэлт дүгнэлт өгч, гаргалаа хайх үүднээс улс төрийн соёлын судалгааг өргөжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгааг улс төр судлаачдад үүгээр дамжуулан уламжилж байна. ■



ПЕТРОВИС
 ХӨГЖИЛ ТҮГЭЭНЭ
 1941 оноос



TRIANGLE



Mobil 1



**PETRO
 MATAD**

*Монгол орны өмнөд булан бүрт
 бид хурч үйлчилнэ!*